

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2021.01.05

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан энэ сард 2 удаа хуралдаж 8 асуудал хэлэлцэн 8 тогтоол баталлаа. Үүнд:

1. Сэлэнгэ аймгийн 2021 оны төсөв батлах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн төсвийн нийт орлогыг 88.3 тэрбум төгрөгөөр төсөвлөлөө.

2. Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бодлогын хороодыг байгуулах тухай асуудлыг хэлэлцээд Эдийн засаг төсвийн бодлогын хороо, Нийгмийн бодлогын хороо, Нутгийн удирдлага, хууль хяналтын бодлогын хороо, Дэд бүтэц, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн бодлогын хороо, Байгаль орчин, аялал жуулчлалын бодлогын хороодыг байгууллаа.

3. Сэлэнгэ аймагт ойгоос 2021 онд мод бэлтгэх хуваарь

4. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн ёс зүйн дүрэм

5. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бодлогын хороодын ажиллах журам

6. Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

7. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

8. Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг тус тус хэлэлцэн баталлаа.

Мөн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 2 удаа хуралдаж дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын III хуралдааныг 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зарлан, цахимаар хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоов. Үүнд:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчийн ёс зүйн дүрмийн төсөл

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бодлогын хороодын ажиллах журмын төсөл

- Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай

- Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай

- Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө батлах тухай.

2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай

3. Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

4. Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” 209 дүгээр тогтоолын хүрээнд аймгийн Онцгой комиссын даргын баталсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх хугацаанд аймгийн хэмжээнд коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг чангатгах, эрчимжүүлэх төлөвлөгөө”-ний дагуу хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулан ажиллаж байна.

Улсын Онцгой комиссоос аймаг, нийслэлийн Онцгой комиссын дарга нарт өгсөн чиглэлийн дагуу агентлаг, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын ажилтнуудын 70 хүртэлх хувийг гэрээс нь ажиллуулж байна.

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Сэлэнгэ аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2021 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж, батлуулсан.

Аймгийн Засаг дарга буюу Онцгой комиссын дарга Ш.Оргил Ерөө сумын Онцгой комисст автомат халуун хэмжигч 1, маск 5000 ширхэг, түргэн оношлуур 100 ширхэгийг хүлээлгэн өгч, өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажиллах болон өвлийг өнтэй даван туулах талаар үүрэг, чиглэл болголоо.

Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас улсын хэмжээнд “E-Mongolia” төслийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулахад үр бүтээлтэй ажиллаж буй шилдэг операторуудыг шалгаруулж, манлайлан ажилласан шилдэг ОПЕРАТОР-оор Мандал сумын ЗДТГ-ын ажилтан, оператор Х.БАТБАЯР шалгарсан.

Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар: Эрүүл мэндийн яамтай хамтран “ЭРҮҮЛ СЭЛЭНГЭ-ЭРҮҮЛ БҮС НУТАГ”-ийг тодорхойлох зорилтын хүрээнд Сүхбаатар сумын өрх бүрээс 1 иргэнийг PCR-ийн шинжилгээнд хамруулах ажлыг 12 дугаар сарын 11, 12-ны өдөр зохион байгуулж, 4649 иргэн хамрагдаж хариу бүгд “СӨРӨГ” гарсан.

Аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” А/348 дугаар захирамжийн хүрээнд аймгийн Алтанбулаг, Сүхбаатар сумдыг 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн 06:00 цагаас эхлэн Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн.

Аймгийн Онцгой комиссын 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн “Хяналтын цэгийн талаар авах арга хэмжээний тухай” 01 дүгээр тогтоолыг сумдын Онцгой комисст хүргүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

“Коронавируст /Ковид-19/-ын халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагуудад дагаж мөрдөх журам”-ын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагуудад халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэн ажиллаж байна.

Сүхбаатар сумаас гадагш Улаанбаатар хот, бусад аймаг орон нутаг руу 24 тээврийн хэрэгсэлд нэвтрэх зөвшөөрөл олгож, Сүхбаатар сум руу 28 тээврийн хэрэгсэлтэй 64 иргэн нэвтэрсэн.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ: Аймгийн хэмжээнд нийт 217 батлагдсан тохиолдол бүртгэгдэж, ХӨСҮТ болон Цэргийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлэн эмчлэгдэж байна. Энэ хугацаанд эдгэсэн иргэдээ татан авах ажлыг тогтмол зохион байгуулж, 1 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар батлагдсан тохиолдлын 85.7 хувь буюу 186 иргэн эдгэрч, 126 иргэн бүрэн эдгэрч хяналтаас гарсан, сувилалын хяналтад 6, гэрийн ажиглалтад 54 иргэн байна.

Батлагдсан тохиолдлын ойрын болон дам хавьтлыг судлах, эцэслэн тогтоох чиглэлээр тандалтын баг, цагдаа, тагнуулын байгууллага хамтран ажиллаж, 1 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар аймгийн хэмжээнд нийт 1486 иргэн хавьталын судалгаанд бүртгэгдэж 1463 иргэний хяналтын хугацаа дуусч гэрийн тусгаарлалтаас гарсан.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн “Ковид”-ын тасагт эмчлэгдэж байсан 21 өвчтөнөөс 2 хүн бүрэн эдгэрч хяналтаас гарсан. 5 иргэн дараагийн шатны сувилалд шилжин эмчлэгдэж, 1 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар 13 өвчтөн тус тасагт хэвтэн эмчлүүлж байна. Биеийн байдал хөнгөн байна.

Аймгийн хэмжээнд шинжилгээ авах 8 баг ажиллаж, 1 дүгээр сарын 04-ний өдрийн байдлаар батлагдсан болон сэжигтэй тохиолдлын 489 хүний сорьц авч /PCR/ өссөн дүнгээр 27458 хүнийг баталгаажуулах шатны шинжилгээнд хамруулж, түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд Сүхбаатар суманд 19645, бусад суманд 25208, нийт 44853 хүнийг хамруулж ажиллалаа.

Аймгийн Онцгой комиссын 70363684 дугаарын утсанд 24 цагийн байдлаар дундажаар 60-75 удаагийн мэдээ дуудлага ирж, дуудлагын дагуу холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байна.

Тусгаарлан ажиглалт болон хэв журам, хяналтын цэгийн үйл ажиллагаа: Аймгийн хэмжээнд нийт 3 байршилд буюу ажиглалтын 2, тусгаарлах 1 байранд 49 иргэн хяналтад байна. Тусгаарлах байрны ажиглалтын цэг байршилд Цагдаагийн 3, Онцгой байдлын 3, Эрүүл мэндийн 8 ажилтан, алба хаагч, 3 нэгж техник хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж байна.

Аймгийн хэмжээнд автозамын шалган нэвтрүүлэх болон хэв журам сахиулах чиглэлээр хяналтын нийт 34 цэг байршилд Цагдаагийн 35, Онцгой байдлын 31, бусад салбарын 34 албан хаагч, 68 нэгж техник хэрэгсэлтэй 24 цагаар үүрэг гүйцэтгэж байна.

Сүхбаатар сумын хэмжээнд автомашин, иргэдийн хөдөлгөөнд 52 цэгт, нийт 122 албан хаагч давхардсан тоогоор 240 тээврийн хэрэгсэлд хяналт тавьж, дугаарын хязгаарлалт зөрчсөн 41 тээврийн хэрэгслийг буцааж, 420 иргэдийн хөдөлгөөнийг хянаж, хөл хорионы дэглэмийг сахиулах коронавируст халдвар “Ковид-19”-ын цар тахлаас өөрийгөө болон бусдыг хамгаалах, маскаа тогтмол зүүх, олон хүнтэй уулзахгүй байх талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Хилийн боомтуудын үйл ажиллагаа: Алтанбулаг хилийн боомтын **орох, гарах** чиглэлд зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнгүй.

Боомтын хяналт шалгалтын талбайд ачааны 6 автомашин /Импортын 2, жолооч нь тусгаарлагдсан 4/, суудлын 1 автомашин, нийт 7 автомашин байрлаж байна.

ОХУ-ын “Хиагт”-ын авто замын боомтоос 20 гаруй ачааны автомашин орох чиглэлд зогсож байна.

Алтанбулаг хилийн боомтод хилийн хяналтын байгууллага /Хилийн 0101

дүгээр анги 14, Гааль 10, ХМХА 2, ГИХА 2 /-уудын 28 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна.

“Сүхбаатар” төмөр замын шалган нэвтрүүлэх боомтоор улсын хилээр орох- гарах чиглэлд ачаа тээврийн 17 галт тэрэгний 677 вагон, 1 орны 31 хөлөг ажилтныг хялбаршуулсан журмаар шалган нэвтрүүлсэн.

Ариутгал халдваргүйтгэлийн мэдээ /өссөн дүнгээр/: Аймгийн хэмжээнд 2020 оны 11 дүгээр сарын 14-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 03-ны өдрүүдэд голомтын халдваргүйжүүлэлтийг 834 объектод 505100.6 м2 талбайд Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, Зооноз өвчин судлалын төв, урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн зам талбайд 212720 м2 талбайд Онцгой байдлын газар, байрны орц, хонгил, гадна талбайд 163318.5 м2 талбайд ЗӨСТ, МЭГ, хүнсний худалдааны газруудад 134110 м2 талбайд Мал эмнэлгийн газрын халдваргүйтгэлийн баг халдваргүйжүүлэлтийг хийж, аймгийн хэмжээнд голомтын болон урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг нийт 1015249.1 м2 талбайд, 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 20 цагийн байдлаар 2 объектын 780 м2 талбайд голомтын эцсийн халдваргүйтгэлийг хийж, хяналт тавин ажиллалаа.

Урьдчилан сэргийлэх, ухуулга сурталчилгааны ажилд: Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж, зөвлөгөө, сэрэмжлүүлэг бэлтгэн “Миний Монгол Энтертаймент” телевизээр, аймгийн болон төрийн байгууллагуудын цахим хуудсанд байршуулан иргэдэд хүргэн ажиллаж байна.

Онцгой байдлын хэлтэс Мандал суманд, Гал түймэр унтраах, аврах 36 дугаар ангийн үндсэн албаны автомашин, Эрэн хайх, аврах анги Сүхбаатар суманд, Гал түймэр унтраах, аврах 40 дүгээр анги Баянгол суманд, Гал түймэр унтраах, аврах 61 дүгээр анги Сайхан суманд, Эрэн хайх, аврах салбар Хүдэр сумын гэрхорооллын гудамжталбайд, сум орон нутгийн төвлөрсөн байр орон сууцны гадна талбай, авто зам дагуу коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж, зөвлөгөөг шуурхай албаны 6 автомашинтай 12 алба хаагч ард иргэдэд хүргэн ажиллаж байна.

Бусад сумдын Засаг даргын Тамгын газарт ард иргэдэд гэрээсээ гарахгүй байх халдвар хамгааллын дэглэмийг баримтлах чиглэлээр ухуулга сурталчилгааны ажлыг тасралтгүй зохион байгуулах чиглэлээр үүрэг өгч ажиллаж байна.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Уул уурхай хайгуулын үйл ажиллагаа эрхлэгч, ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүн олборлогч, экспортлогч, тэдгээрийн туслан гүйцэтгэгч, уул уурхай, газрын тосны салбарын үйл ажиллагаанд ажил үйлчилгээ ханган нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдэд коронавируст халдвар /Ковид-19/ аас урьдчилан сэргийлэх, халдвар, хамгааллын дэглэмийг сахиулах, шинжилгээ өгөх нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын даргаас хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар үүрэг чиглэл өгч, мэргэжлийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхцөл байдлын мэдээллийг сонсож, холбогдох шийдвэрийг гарган ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын даргын баталсан Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт коронавирусын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг чангатгах,

эрчимжүүлэх ажиллагааны хүрээнд эргүүл, хяналтын ажлыг 10 байгууллагын 161 албан хаагч 08:00-20:00 цагийн хооронд гүйцэтгэн ажиллаж байна.

Мандал сумын нутаг дэвсгэрийг бүслэн хаах хяналтын 9 цэгийг байршуулж Онцгой, Цагдаа, СЗДТГ-ын нийт 21 ажилтан, албан хаагч, албаны 4, хувийн 5 тээврийн хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж байна.

12 дугаар сарын байдлаар гамшиг ослын буюу объектын гал түймрийн 8 удаагийн дуудлага ирж холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” 209 дүгээр тогтоол, МХЕГ-ын даргын 2020 оны А/146 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулахаар дараах хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Тусгаарлах байруудын халдваргүйжүүлэлт болон халдвар хамгааллын дэглэмд хяналт хийх: Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2020 оны 01/253 дугаар удирдамжийн дагуу “Номин” зочид буудлын тусгаарлан ажиглах байрны хоол үйлдвэрлэлийн ажилчдын ариун цэвэр, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ, дүгнэлт өгөх зорилгоор 13 арчдас, тусгаарлан ажиглалтад байгаа иргэдэд өгч буй өдрийн хоолны илчлэгийг тодорхойлохоор 5 нэр төрлийн хоол, аймгийн Нэгдсэн эмнэлгийн хоол үйлдвэрлэлийн ажиллагсдын ариун цэвэр, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ, дүгнэлт өгөх зорилгоор 17 арчдас, хоол үйлдвэрлэлд хэрэглэж буй ундны уснаас ундны усны чанар, аюулгүй байдлын үзүүлэлт тодорхойлохоор 2 дээж тус тус авч аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулахад илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллаж байна.

Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчооны хяналт, шалгалт: Аймгийн хэмжээнд 11 дүгээр сарын 12-ны өдрөөс өссөн дүнгээр орох чиглэлээр нийт 2615 тээврийн хэрэгслээр 8986 иргэн орсон. Үүнээс хувийн 2281 автомашинаар 5786 иргэн, албан томилолтор 68 машинаар 90 иргэн, бусад /ачаа тээвэр, эмнэлэг/ 271 тээврийн хэрэгсэл орсон. Гарах чиглэлээр нийт 3027 тээврийн хэрэгслээр 7935 иргэн гарсан. Үүнээс хувийн 2383 автомашинаар 6942 иргэн, албан томилолтоор 41 тээврийн хэрэгслээр 49 иргэн, бусад /ачаа тээвэр, эмнэлэг/ 603 тээврийн хэрэгсэл гарсан байна.

12 дугаар сарын 05-25-ны өдрүүдэд нийт 85 нийтийн тээврийн хэрэгслээр 2975 иргэн /PCR шинжилгээнд хамрагдсан/ орж, 23 нийтийн тээврийн хэрэгслээр 527 иргэн гарсан. Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 12 сарын 14-ний өдөр шинэчлэн батлагдсан 156 дугаар “Хот хоорондын зорчигч тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам”-ын хэрэгжилтийг хангуулан нийтийн тээврээр зорчин ирсэн иргэдийн бүртгэлийг хөтлөн, тээвэрлэлт гүйцэтгэсэн 108 автобусыг ЗӨСТ-өөс халдваргүйтгэл хийхэд хяналт тавин ажиллахад дээрх хугацаанд орсон, гарсан тээврийн хэрэгсэл болон зорчигчийн хяналтаар зөрчил илрээгүй байна.

Худалдаа үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх: МХЕГ-ын даргын баталсан 01/13, 01/248 дугаартай удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хугацаанд хүнсний худалдааны 421 объектод төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, батлагдсан тохиолдлын явсан маршрутын дагуу худалдааны газруудад голомтын халдваргүйжүүлэлт хийх явцад

хөндлөнгийн хяналт, хөдөлмөр зохицуулалтыг хийлгэн, ээлжийг солих арга хэмжээг авч, зохицуулалт хийх боломжгүй 2 хүнсний дэлгүүр, 1 худалдааны төв, 2 талхны цехийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох арга хэмжээг авч, хяналт тавин ажиллаж байна. Шалгалтын явцад 469 зөрчлийг илрүүлж, 257 зөрчлийг арилгуулж, 170 заалттай 12 зөвлөмжийг өгч, 80 хувьтай хэрэгжсэн. Дуусах хугацаа хэтэрсэн 58 нэр төрлийн 420 ширхэг, 1186.0 мян.төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг устгалаа.

Мөн дээрх үйлчилгээний байгууллагууд үйлчлүүлэгчийн биеийн халууныг хэмжиж бүртгэл хөтөлсөн, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан албан хаагчид амны хаалттай, хүн хоорондын зай барьж үйлчлүүлэх тэмдэглэгээг хийсэн, түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын горим хугацаа, гарал үүслийн баталгаажилт бүрэн, гар халдваргүйжүүлэх нөхцлийг бүрдүүлж, спиртэн суурьтай гар ариутгагч бодисыг хэрэглэж, ажлын байрны угаалга, цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвшсэн байна.

Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Сүхбаатар суманд ажиллаж буй 2 шатахуун түгээх станцын 7 хийн түгээгүүр шалгалт баталгаажуулалтад хамрууллаа.

Механикийн хэмжлийн төрлөөр: Сүхбаатар суманд махны худалдаа эрхэлдэг 1 иргэний 2 жинг шалган баталгаажууллаа.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Өнгөрсөн сард 1342 баримтаар 8.585751.7 мян.төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна.

11 дүгээр сарын тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт тавьсан.

ТАЦНС-д нэвтэрч байгаатай холбогдуулан бүх байгууллагын дарга, нябо нарын гарын үсгийг нэг бүрчлэн оруулж дуусгасан.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		95,693,983.3	89,205,778.5	93.2
1.1	Орон нутгийн төсвийн орлого	27,120,005.7	25,590,594.9	94.4
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	18,865,369.6	15,134,548.1	80.2
	Сумдын төсвийн орлого	8,254,636.1	10,456,046.7	126.7
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	5,083,811.7	5,083,811.7	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	51,125,035.4	48,872,856.1	95.6
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	6,650,563.7	5,849,849.7	88.0
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	1,728,732.9	1,728,732.9	100.0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	2,079,933.2	2,079,933.2	100.0
1.7	Сум хөгжүүлэх сан /орлого/	1,905,900.7	699,040.5	36.7
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		95,693,983.3	77,849,604.5	81.4

	Орон нутгийн төсвийн нийт зарлага	95,693,983.3	77,849,604.5	81.4
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	19,520,084.4	14,441,828.9	74.0
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	2,902,720.6	1,875,136.1	64.6
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	15,491,251.3	11,557,546.1	74.6
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,854,784.5	998,007.8	53.8
2.1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	4,598,759.8	2,880,107.0	62.6
	Халамжийн сан	162,175.0	118,210.3	72.9
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	8,253,180.6	6,995,090.6	84.8
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	622,351.4	566,130.5	91.0
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	56,766,866.2	48,996,235.6	86.3
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	1,013,060.4	978,857.7	96.6
	3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг	71,680,027.6	66,111,358.9	92.2
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	13,904,428.5	11,388,653.1	81.9
	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	2,612,103.2	2,392,725.7	91.6
3.2	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	129,563.5	129,563.5	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	
	Хөрөнгө оруулалтын зардалд	2,482,539.7	2,263,162.2	91.2
	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	4,038,460.5	3,457,124.0	85.6
3.3	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	3,697,303.7	3,115,967.2	84.3
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	319,500.0	319,500.0	100.0
	Усан хангамжийн татаас	21,656.8	21,656.8	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	50,173,801.4	47,921,622.1	95.5
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	951,234.0	951,234.0	100.0
	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	51,125,035.4	48,872,856.1	95.6
	- Ерөнхий боловсролын сургууль	28,027,564.5	27,129,865.0	96.8
3.6	- Хүүхдийн цэцэрлэг	15,185,484.5	13,831,004.7	91.1
	- Эрүүл мэндийн байгууллага	6,818,670.6	6,818,670.6	100.0
	- Газрын кадастрын байгууллага	549,705.8	549,705.8	100.0
	- Хүүхдийн байгууллага	543,610.0	543,610.0	100.0
	4. Тусгай сангуудын зарлага	1,905,900.7	699,040.5	36.7
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	1,905,900.7	699,040.5	36.7

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2019 11- сар	2020 11- сар	<u>2020- 11</u> <u>2019-11</u> Х/төгрөгөөр /
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 200	1 300	108.3
	Талх /орон нутгийн, ш/	1 200	1 300	108.3
	Нарийн боов /кг/	2 500	2 600	104.0
	Будаа /кг/	2 400	2 600	108.3
	Элсэн чихэр /кг/	2 200	2 200	100.0
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	7 800	6 800	87.2
	Үхрийн мах /кг/	8 500	7 800	91.8
	Адууны мах /кг/	7 000	6 500	92.9
	Ямааны мах /кг/	6 500	6 500	100.0
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	4 000	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	11 000	110.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 000	1 300	130.0
	Сүү / савласан, л/	2 700	3200	118.5
	Тараг /задгай, л/	1 300	1 500	115.4
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 000	16 000	106.7
	Айраг /л/	3 500	4 000	114.3
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	400	114.3
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	4 500	118.4
	Өөхөн тос /кг/	2 000	2 500	125.0
	Шар тос /кг/	13 000	15 000	115.4
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	800	1 000	125.0
	Лууван /кг/	1100	1 000	90.9
	Манжин /кг/	1500	1 200	80.0
	Байцаа /кг/	1200	1 200	100.0
	Сонгино /кг/	1500	2 500	166.7
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	4 500	128.6
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 800	3 000	107.1
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 750	1 400	80.0
	Бензин А - 92	1 840	1 470	79.9
	Дизелийн түлш	2 370	2090	88.2

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй “Зөв зөвд, шударга зөв” сэдэвт соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулж байгаатай холбогдуулан Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 02/1100 албан тоотоор “Цахим орчинд соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах” чиглэлийг агентлагуудад хүргүүлж, биелэлтийг нэгтгэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн ажилласан.

Хууль зүй дотоод хэргийн сайдын Сэлэнгэ аймгийн Засаг даргатай 2020 онд хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний биелэлтийг харьяа агентлагуудаас татан авч нэгтгэн, 97.5 хувийн үнэлгээтэйгээр Хууль зүйн дотоод хэргийн сайдад хүргүүлэн тайлагнасан.

Сумдын Засаг даргад томилуулахаар нэр дэвшүүлсэн 17 сумдын иргэдийн хувийн ашиг сонихрлын урьдчилсан мэдүүлгийг хянуулж, хариу дүгнэлтийн дагуу Засаг дарга нарыг чөлөөлж, томиллоо.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үеийн нөхцөлд Архивын тасгийн ажиллах горим, хүн хүчний талаарх саналыг боловсруулж, архивын лавлагааг сумдын Засаг даргын тамгын газраар дамжуулан цахимаар үнэ төлбөргүй өгч байна.

Цагдаагийн газар: Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 12 сард 416 холбогдогчтой 1314.6 сая төгрөгийн хохиролтой, 557 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 163 хэргээр буюу 22.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 51.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 3.3 хувиар буурсан байна.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Боловсрол, соёл урлаг, спортын талаар:

Боловсрол, шинжлэх ухааны яамны тусгай хэрэгцээт боловсролын хэлтсээс ирүүлсэн асуулгын дагуу ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчин нөхцөл бүрдсэн эсэх талаар болон багш нарын заах арга зүй, чадамжийн талаарх асуулга судалгааг авлаа. Боловсролын хүрээлэнгээс сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрэглэж буй хэрэглэгдэхүүний ашиглалт, хүртээмжийн өнөөгийн нөхцөл байдлын талаар асуулга судалгааг цахимаар зохион байгуулж, 35 сургуулийн захирал, 43 цэцэрлэгийн эрхлэгч, 1000 гаруй багшийг оролцууллаа.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтнуудын болон судлагдахуун бүрийн багш нарын цахим группт “Жендерт суурилсан хүчирхийллийн эсрэг 16 хоногийн аян”-д нэгдэхийг уриалж, хүчирхийллийг таслан зогсооход хүн бүрийн дуу хоолойг нэгтгэн, эерэг хандлагыг түгээх арга хэмжээг зохион байгуулж байгаа бөгөөд сургууль, цэцэрлэг бүр нэгдэн, өөр өөрийн онцлогт тохирсон арга хэлбэрээр нөлөөллийн арга хэмжээнүүдийг явуулж байна.

“Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлж, мэргэжлийн стандартыг нэвтрүүлэн, үнэлэмжийг хөдөлмөрийн бүтээмж, гүйцэтгэлд суурилсан тогтолцоонд шилжүүлэх зорилт дэвшүүлсний дагуу Боловсрол, шинжлэх ухааны яамнаас байгуулсан ажлын хэсэг “Чадварлаг багш” арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний төслийн хэлэлцүүлгийг 12 дугаар сарын 01-ний өдөр цахимаар зохион байгуулахад 12 мэргэжилтэн оролцлоо. “Чадварлаг багш” хөтөлбөрт тусгуулах саналыг сургууль,

цэцэрлэг бүрээс авч, нэгтгэн боловсруулж, Боловсрол шинжлэх ухааны яаманд хүргүүлж ажилласан.

Аймгийн нийт Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх зорилгоор аймгийн Засаг даргын 2013 оны А/451 тоот захирамжаар батлагдсан “Үйлчлүүлэгчдээс төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагааны талаар санал асуулга авах журам”-ын дагуу багш, сурагч, эцэг эхчүүдээс боловсролын үйлчилгээ, теле хичээлийн талаар цахим хэлбэрээр асуулга, судалгааг авч, нэгтгэн боловсруулж ажилласан.

Боловсрол шинжлэх ухааны сайдын 2020 оны А/162 тоот хүнсний дэмжлэг үзүүлэх тухай тушаалын дагуу хоол тэжээлийн дутагдалд орж зорилтот өрхийн хүүхдүүдэд дотуур байр, үдийн цай, цэцэрлэгийн хүүхдийн хүнсний нөөцөөс эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан байдлаар багцлан ерөнхий боловсролын сургуулийн 351, цэцэрлэгийн 225 хүүхдэд олгоод байна. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын сайн дурын хандив тусламжийг 1000 гаруй өрхийн 2000 орчим хүүхдэд хүргэсэн.

Боловсрол шинжлэх ухааны яамны бага, дунд боловсролын газраас зохион байгуулсан цахим хуралд оролцож, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2020 оны А/180 “Заавар батлах тухай” тушаалыг хэрэгжүүлэх арга зүйтэй танилцаж, теле хичээлийн чанар, хүртээмжийг сайжруулах чиглэл өгснийг захирлуудад хүргэлээ.

Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтсээс хүүхэд багачуудад зориулсан 3 контентыг аймгийн нийт боловсролын байгууллагын багш, ажилтан, сурагч, эцэг эхчүүдэд түгээж, шударга ёсны зарчим, үнэт зүйлсийг бий болгоход дэмжин ажиллаж байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хөл хорио тогтоосон хугацаанд ерөнхий боловсролын сургуулиуд суралцагчийн 1 дүгээр улирлын үнэлгээг гаргаж, цахимаар зохион байгуулж буй уралдаан тэмцээн, аянд суралцагчдын 78.0 хувь буюу 16527 суралцагчийг оролцуулсан бол цэцэрлэгүүд 59.2 хувь буюу 4629 хүүхдийг оролцуулж, идэвхжүүлэх үйл ажиллагааг явуулж байна.

Теле хичээл үзсэн байдлын хувьд 11 дүгээр сарын 11-нээс 12 дугаар сарын 18-ны хооронд цэцэрлэгийн хүүхдүүдийнх 1.1 хувь, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдынх 3 долоо хоногт өссөн, 2 долоо хоногт буурсан, дундаж нь 2 долоо хоногт буурсан боловч сүүлийн 3 долоо хоногт 0.1-1.2 хувь өссөн үзүүлэлттэй байна.

Боловсрол шинжлэх ухааны яамнаас “Боловсролын ерөнхий хуулийн хэлэлцүүлэг”-ийг зохион байгуулахад 35 цэгээс 320 гаруй багш, ажилтан оролцож, хуулинд нэмж тусгуулах, өөрчлөх саналаа хэлэлцүүлээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир спортын газар, Боловсрол соёл урлагийн газар, Сэлэнгэ цахим телевиз хамтран 17 сум 6 тосгонд 5 ангилалд “Гэр гэртээ дасгалаа хийе” цахим уралдааныг зохион байгуулж, ангилал тус бүрт 1, 2, 3, тусгай байрыг шалгаруулж урамшуулж ажиллалаа.

2. Эрүүл мэндийн талаар:

Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс хуваарилагдсан томуугийн 2300 хүн тун вакциныг татан авчирч сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хуваарилан хүргүүлж, 1496 хүнийг томуугийн вакцинд хамруулан ажиллалаа.

Гэрийн эргэлтээр 6-11 сартай нийт хүүхдийн 86.6 хувь буюу 3637 хүүхдэд, 12-59 сартай нийт хүүхдийн 97.8 хувь буюу 9098 хүүхдийг эргэж, А аминдэмийн дархлаажуулалтад хамрагдах нийт хүүхдийг хамрууллаа.

“Таны Сэлэнгэ”, “Мандал ТВ”, Сайхан сумын “Эрдэнэ ТВ”-үүдтэй гэрээ байгуулан нийгмийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх 3 төрлийн 24 видео шторк, мэдээллийг аймгийнхаа 30000 гаруй иргэдэд түгээн ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын ивээл дор “Хавдаргүй Үрс” анхдугаар зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулж, давхардсан тоогоор 71 хүүхдийн эмч, их эмч, дүн бүртгэгч, сувилагч нарыг, мөн Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс “Коронавируст халдварын үед зохиомол амьсгалын цогц менежмент” сэдэвт цахим сургалтыг зохион байгуулж, сургалтад аймгийн “Нэгдсэн эмнэлэг”, Мандал сумын “Нэгдсэн эмнэлэг”, Сайхан сумын “Хөтөл сум дундын эмнэлэг”-ийн эрчимт эмчилгээ, яаралтай түргэн тусламжийн 65 эмнэлгийн мэргэжилтнийг хамруулж ажиллалаа.

3. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газраас тендерт шалгарч сэргээн засах үйлчилгээ явуулах эрх бүхий “ЭБУС” ХХК, “Бум хараа” ХХК, “Энэрэлт үйлс” ХХК, “Хараа Алтан-Од” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан Сэргээн засах 8 төрлийн үйлчилгээнд 5-7 хоногийн хугацаатай Сүхбаатар суманд 133, Мандал суманд 138 нийт 271 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг хамрууллаа.

Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дэргэдэх Сүхбаатар, Баянгол, Мандал сумын ахмадын сувилал нь тус онд 43 ээлжээр нийт 565 ахмад настанд эмийн болон эмийн бус эмчилгээ сувилгааг үзүүлж ажилласан.

Өрхийн малжуулах ажил арга хэмжээний хүрээнд Баруунбүрэн, Сант, Зүүнбүрэн, Хушаат, Хүдэр, Ерөө сум, Бугант, Хэрх тосгоны 30 өрхийг хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 141000.0 мян.төгрөгийг зарцуулж, 60 ажлын байрыг шинээр бий болгож ажиллалаа. Мөн Сайхан, Түшиг, Ерөө, Цагааннуур сумдын хувиараа хөдөлмөр эрхлэгч, ахмад мэргэжилтний зөвлөх 8 иргэнд “Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт” 1620.0 мян.төгрөг, “Эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг”-т “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгт Сүхбаатар суманд худалдаа үйлчилгээний чиглэлээр 2 төслийг дэмжин “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-аас 10000.0 мян.төгрөг, “Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн хүрээнд Сүхбаатар, Баянгол, Сант сумдын хувиараа хөдөлмөр эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй 3 иргэнд ажлын байрын түрээсийн хөнгөлөлт 640.0 мян.төгрөг, Сүхбаатар сумын хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучуудын 2 бүлэгт ажлын байрын түрээсийн хөнгөлөлт болох 700.0 мян.төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож ажиллалаа.

4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах чиглэлээр 12 зөвлөмж, 20 контент, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх талаар 6 шторк, мэдээллийг гаргаж иргэдэд хүргэн ажиллаж байна. Нийт мэдээллийн 40 хувь нь ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, 60 хувь нь хүүхдийн хөгжил оролцоог хангах, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр бэлтгэж, аймгийн Засаг даргын Тамгын газар, Сэлэнгэ хүүхэд, Орхонтуул хүүхэд, Сэлэнгэ залуучууд хөгжлийн төв, “Миний

монгол” телевиз, “Мандал” кабелийн телевиз зэрэг орон нутгийн мэдээллийн 6 сувгаар, мөн “Монголын Үндэсний олон нийтийн радио телевиз”, “Өнөөдөр” сонин, “Зиндаа” сайтад мэдээллийг хүргүүлж, иргэд олон нийтийг мэдээллээр ханган ажиллалаа. Мөн “Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг” 16 хоногийн аяны хүрээнд видео бичлэг 10, 5 төрлийн постерийг “Сэлэнгэ хүүхэд”, “Сэлэнгэ Залуучууд хөгжлийн төв”, “Орхонтуул хүүхэд хөгжлийн төв”, “Зүүнхараа хүүхдийн ордон” фэйсбүүк хуудсанд байршуулж иргэдэд хүргэж ажиллалаа.

Мандал, Алтанбулаг сумын түр хамгаалах байрны бэлэн байдлыг ханган хоол хүнс, бараа материал, эм эмийн хэрэгслийн нөөц, ажилтан албан хаагчийн аюулгүй байдлын үүднээс хамгаалалтын иж бүрэн хувцас, хэрэгслээр хангаад байна.

18 байгууллагын эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан эрсдэлт нөхцөлд байгаа ажилтан, албан хаагчдын 94 өрхөд хүнс, ахуйн хэрэглээний дэмжлэг үзүүлж ажилласан.

“Зүүнхараа хүүхдийн ордон”-ы цахим хаягаар дамжуулан шатрын тэмцээнийг зохион байгуулж, 218 хүүхэд оролцсон.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

1. Мал эмнэлгийн үйлчилгээний талаар:

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 01/1312 тоот, аймгийн Засаг даргын А/309 тоот захирамжийн хүрээнд аймгийн хэмжээнд 2020 онд “Мал эмнэлгийн нэгдсэн цахим систем”-ээр мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд нийт 16613 ширхэг мал эмнэлгийн гэрчилгээг хүнсний хэрэглээ, худалдаа, үржлийн зориулалтаар, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнийг бүрэн хянаж, баталгаажуулж олгосон байна. Үүнд адуу 49183, үхэр 21512, тэмээ 49, хонь 69731, ямаа 42618, гахай 517, тахиа 68, нохой 3, туулай 4 буюу нийт 183694 толгой мал, амьтан, 588249 кг мах, махан бүтээгдэхүүн, 792469 л сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг 14, зөгийн бал 2520 кг, арьс шир, түүхий эд бүтээгдэхүүн 84068 ширхэг бүтээгдэхүүнийг тус тус хянан баталгаажуулж, олгосон байна.

“Малчин өрхийн эрүүл мэндийн дэвтрийг 17 сумын 9833 малчин, мал бүхий өрхөд олгохоос 96.1 хувь буюу 9453 малчин, мал бүхий өрхийн өрхөд олгож хөтлөлтөнд хяналт тавин, Мал, амьтны эрүүл мэндийн үзлэгт давхардсан тоогоор адуу 42300 толгой, үхэр 707620 толгой, хонь 1622536 толгой, ямаа 1033964 толгой, амьтан 63820 толгой буюу нийт 3470300 толгой мал, амьтныг хамруулж, өнөөдрийн байдлаар аймгийн хэмжээнд халдварт, гоц халдварт өвчингүй байна. Аймгийн хэмжээнд шимэгчтэх өвчнөөр өвчилсөн 500 толгой мал, амьтан үүнээс үхсэн 49, эдгэрсэн 451 толгой байна.

Аймгийн Засаг даргын А/110 тоот “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” захирамж, МЭЕГ-ийн А/76 тоот тушаалаар шимэгчтэх өвчнөөс эмчлэн болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд угаалганд 3483728 мян.тол хамрагдахаас 3604398 мян.тол, туулгалтанд 3596340 мян.тол хамрагдахаас 3939008 мян.тол, боловсруулалтад 715337 мян.тол хамрагдахаас 956456 мян.тол, нохой, муур заслага 2257 тол хамруулахаас 2327 толгой нийт давхардсан тоогоор 7797662 мян.толгой мал, амьтан хамруулахаас 8502189 мян.тол мал, амьтан буюу 109.0 хувийг технологит хугацаанд бүрэн

хамруулж, гүйцэтгэлийг цахим нэгдсэн системд 100 хувь оруулж хяналт тавин ажилласан.

Угаалга, туулгалт, боловсруулалтын 2020 оны төлөвлөгөөт арга хэмжээг чанартай хэрэгжүүлэх, сумдын Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөөг тогтмол өгч, уг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх заавар, сургалт сурталчилгааг 17 сумын хэмжээнд 425 малчид, мал бүхий иргэдэд өгч ажиллалаа.

Орон нутагт эргүү, бэтэг болон бусад зооноз өвчнөөс сэргийлэх зорилгоор гэрийн тэжээвэр нохойн туулгалтыг технологийн дагуу зохион байгуулж давхардсан тоогоор 43484 толгой нохой хамруулахаас төлөвлөснөөс технологит хугацаанд давхардсан дүнгээр 45907 толгой нохойг хамруулж, баасыг халдваргүйжүүлэн шатааж булж устгах ажлыг зохион байгуулан ажилласан.

Аймгийн Засаг даргын А/110 тоот “Мал эмнэлэг урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” захирамжаар 9601 малын хашаа, байр, тоног хэрэгсэлийн 4134286 м², 388 гахайн байрны 39680 м², 596 шувууны байрны 30175 м², 6540 машин, тоног хэрэгслийн 133293 м² талбай, 1245 түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах цэг, зoorь, тэжээлийн агуулахын 60673 м² талбай, 929 худаг, уст цэгийн 17369 м² талбай, 127 малын хэвтэр, бууцны 1365 м² талбай, голомтын бүсийн 160770 м² талбай, устгалын цэгийн 16400 м² талбай, малын бэлчээрийн 840109 м² талбай, 14476 хүүр, сэг зэмийн 15236 м² талбай, 1024 нийтийн эзэмшлийн 1707474 м² талбайг халдваргүйжүүлснээс гадна аймгийн төв Сүхбаатар суманд ковид-19 өвчин оношлогдож, аймгийн онцгой комиссын шийдвэрээр МЭГ-ын ариутгалын тусгай тоноглогдсон ДУК пургон авто машинтай, 6 хүний бүрэлдэхүүнтэй 2 бүлэг 243 хүнсний худалдаа, үйлчигээний төв, аж ахуйн нэгж, байгууллага, нийтийн эзэмшлийн 393106 м² талбайг халдваргүйжүүлж нийт дүнгээр 7549936 м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/110 тоот “Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд Монгол Улсын засгийн газрын 225 тоот тогтоолын 1, 2, 3 дугаар хавсралтад заагдсан 14 нэр төрлийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад нийт 1584940 толгой мал, амьтан хамрагдахаас 1601846 толгой мал, амьтан буюу 101 хувь хамрагдсан байна.

Аймгийн хэмжээнд гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчнийг эрт илрүүлэх, эмнэлзүй болон ийлдэс судлалын тандалт шинжилгээг улсын Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторитой хамтран баталсан удирдамжийн дагуу эпидемиологийн тооцоонд тулгуурлан санамсаргүй түүврийн аргаар шүлхий өвчний тандалт шинжилгээнд Мандал, Алтанбулаг, Шаамар сумдын 30 өрхийн нийт 450 малын сорьц дээж, бог малын мялзан өвчний тандалт шинжилгээнд Баруунбүрэн, Орхонтуул, Мандал, Сант, Алтанбулаг сумдын 50 өрхийн 700 бог малын сорьц дээж цуглуулан, хот айл бүрийн мэдээлэл, хот айлын асуумж болон сорьц дээжийн бүртгэл, газар зүйн байршил уртраг, өргөрөгийг гар утсанд суурилсан тусгай программ болох LIMS дээр болон цаасан материалаар бүртгэж, цахим бүртгэлд оруулан шинжилгээг хийж, шинжилгээний дүнгээр бүгд сөрөг дүнтэй гарсан.

МЭЭГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, албан даалгаврын хэрэгжилтийг хангах, гоц халдварт өвчний халдварлалтыг эрт илрүүлэх зорилгоор

УМЭАЦТЛ-той хамтран шүлхий өвчнийг оношлох шинжилгээнд Мандал, Алтанбулаг, Шаамар сумдын 312 үхэр, 312 хонь, 312 ямаа бүгд 936 толгой мал, бог малын мялзан өвчнийг оношлох шинжилгээнд Мандал, Алтанбулаг, Шаамар, Орхонтуул, Сант сумдаас бог малын мялзан өвчний шинжилгээнд 512 хонь, 512 ямаа бүгд 1024 толгой мал, сүрьеэ өвчний шинжилгээнд 17 сумын 19800 толгой үхэр, Лейкоз өвчний шинжилгээнд 17 сумын 9780 толгой үхэр, 17 сумаас гахайн 12 өвчний шинжилгээнд 40 толгой гахай буюу нийт 31580 толгой мал амьтныг тандалт шинжилгээнд хамруулж, сорьц дээж цуглуулан шинжилгээ хийх явцад хяналт тавин ажиллалаа.

“Малын эрүүл мэнд хөтөлбөр”-ийн хүрээнд “Бруцеллёзын тандалт-2020” тандалт шинжилгээг аймгийн хэмжээнд 14799 хээлтүүлэгч малыг бруцеллёзын шинжилгээнд хамруулахаас буур 7, бух 4083, хуц 5822, ухна 4882 толгой 99.9 хувь буюу нийт 14794 толгой хээлтүүлэгч, түүвэр аргаар 9700 үнээ шинжилгээнд хамруулахаас 105.8 хувь буюу 10267 толгой үнээнээс тус тус сорьц дээж цуглуулж нийт 25061 толгой хээлтүүлэгч, хээлтэгч мал хамрагдаж 28 толгой хээлтүүлэгч, 13 хээлтэгч нийт 41 толгой мал эерэг гарч хамрагдсан нийт малд эзлэх халдварлалт 0.16 хувь байна.

2. Хөдөө аж ахуйн талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоолоор улсын хэмжээнд коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Улсын онцгой комиссын даргын 2020 оны “Хүнсний хангамжийн удирдлагын шуурхай штаб байгуулах тухай” 21 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны “Хүнсний хангамж, нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах тухай” А/309 тоот захирамжийг сумдад хүргүүлэн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, аймаг орон нутгийн иргэдийг хүнсний бүтээгдэхүүнээр хангах, нөөц бүрдүүлэлт, дэлгүүрүүдийн борлуулалтын мэдээг өдөр тутам авч, төмс, хүнсний ногооны нөөцийн мэдээг 14 хоногт 1 удаа авч, 17 сумын 210 иргэн, аж ахуй нэгжийн нөөцийн мэдээг нэгтэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэн ажиллаж байна.

Монгол мал хөтөлбөрийн хүрээнд махны чиглэлийн 10 бяруун бух авсан. Аймгийн эргэлтийн нийт талбай 305.3 мян.га, жилд дунджаар 170-190 мян.га талбайд үр тариа, тэжээлийн ургамал, тосны ургамал, төмс, хүнсний ногоо тариалдаг. 2020 онд нийт 201.5 мян.га талбайд үр тариа, тосны ургамал, ногоон тэжээл тариалсанаас 153,7 мян.га-д улаанбуудай, 2455 га-д арвай, 5640 га-д овьёос, 4544 га-д гурвалжин будаа, 8027 га-д тэжээлийн ургамал, 27.1 мян.га-д тосны ургамал, 2895 га-д төмс, 3033 га-д хүнсний ногоо тариалсан.

Ургац хураалтын дүнгээр улаанбуудай 138 мян.га талбай хураан авч, нэгж га талбайгаас 12.5 цн буюу 172 мян.тн ургац, тосны ургамал 21 мян.га талбайг хурааж нэгж га талбайгаас 5.2 цн буюу 11 мян.тн ургац, тэжээлийн ургамал 18 мян.га талбайг хурааж нэгж га талбайгаас 12.9 цн буюу 23 мян.тн ургац, төмс 2776 га талбайд хураалт хийгдэж, нэгж га талбайгаас 117 цн буюу 32738 тн ургац, хүнсний ногоо 2885 га талбайд хураалт хийж, нэгж га талбайгаас 121 цн буюу 35 тн ургац хураан авсан байна.

2020 оны улаанбуудайн урамшуулалд хамрагдах 240 аж ахуйн нэгжүүдийн тооцоо нийлсэн акт, бусад материалуудыг цахимаар авч Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам болон хөдөө аж ахуй дэмжих санд хүргүүлж ажиллалаа.

3. Байгаль орчны талаар:

2020 онд ойгоос бэлтгэсэн модны гүйцэтгэлийг сумдаас авч нэгтгэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан, 2021 онд ойгоос бэлтгэх модны саналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн “2021 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг сумдаар батлах тухай” 2020 оны 08 тоот тогтоолоор батлуулж, тогтоолыг мод бэлтгэх зөвлөмжийн хамт сумын болон сум дундын Ойн анги, сумдын ИТХ, Засаг дарга нарт хүргүүлэн ажиллалаа.

ШУА-н “Газар зүй-Геоэкологийн хүрээлэн”-гийн судалгааны багийн гүйцэтгэсэн “Цөлжилт, газрын доройтлын судалгаа”-ны тайлан, сум тус бүрээр цөлжилт, газрын доройтлыг харуулсан зураг, “Цөлжилт газрын доройтлыг бууруулах менежментийн төлөвлөгөө”-ний хамт хүлээн авч үлдэгдэл санхүүжилтийг олгуулсан.

Аймгийн Засаг даргын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/280 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулсан Баянгол сумын “Бороогоулд” ХХК, “Сонортрейд” ХХК, “Тод-Ундрага” ХХК, Ерөө сумын “Ди Зэт энд Ай” ХХК, “Капитал авто сервис” ХХК, “Улз гол” ХХК, “Баяжмал алт” ХХК, “Инфинити спейс” ХХК, “Болдтөмөр Ерөө гол” ХХК, Түшиг сумын “Шар нарст” ХХК, Сайхан сумын “Цемент Шохой” ХК, Тэсрэх бодисын үйлдвэр болох “Монтай-Эрдэнэ” ХХК зэрэг 12 аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг дүгнэж, 2020 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн гаргаж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллалаа.

Ойн дагалт баялаг /хуш модны самар/ түүж бэлтгэсэн мэдээг нэгтгэн холбогдох газруудад хүргүүлсэн. Үүнд: Хүдэр сум 26 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан 778.4 тн самар түүж, орон нутгийн орлогод 1.080.000.0 төгрөг, Мандал сум 19 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан, 1676.2 тн самар түүж, орон нутгийн орлогод 2.146.500.0 төгрөг, Ерөө сум 22 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан 3100 тн самар түүж, орон нутгийн орлогод 1.454.000.0 төгрөг, Баруунбүрэн сум 10 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан 188.2 тн самар түүж, орон нутгийн орлогод 292.000.0 төгрөг төвлөрүүлсэн.

4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар:

Сумдын 2021 оны газар зохион байгуулалтын батлагдсан төлөвлөгөөг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд төслийн шатны 10 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан төлөвлөгөөг баталгаажуулаад байна.

2020 оны газрын нэгдмэл сангийн ГТ-6 /Газрын хохирлын тайлан/, ГТ -7 /Газрын хамгааллын тайлан/ тайлан бүх сумдаас авч нэгтгэн ГЗБГЗЗГ–т хүргүүллээ. ГТ-6 тайлангаар Сэлэнгэ аймагт 2020 оны байдлаар нийт 68588.21 га газар хохиролд орсон байна. Үүнд:

- Тариалангийн газар 15135.15 га
- Бэлчээр ба бусад өвслөг ургамлын газар 33276.29 га
- Хот тосгон бусад суурины газар 317.12 га

- Ойн сан бүхий газар 13798.06 га
 - Усан сан бүхий газар 1.79 га
 - Уурхайн эдэлбэр газар 6059.8 га тус тус хохиролд ороод байна.
- ГТ -7 /Газрын хамгааллын тайлан/-р Сэлэнгэ аймагт 2020 оны байдлаар нийт 104319.9 га газарт хамгаалах арга хэмжээ авсан байна. Үүнд:

- Тариалангийн газар 33962.9 га
- Бэлчээр ба бусад өвслөг ургамлын газар 68461.7 га
- Хот тосгон бусад суурины газар 81.42 га
- Ойн сан бүхий газар 1760.71 га
- Усан сан бүхий газар 2.18 га
- Уурхайн эдэлбэр 50.95 га газарт тус тус хамгаалах арга хэмжээ авсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан Улсын комиссын бүрэлдэхүүн 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн БХБЯ-ны сайдын 1/3859 тоот зөвлөмжийн дагуу доорх ажлуудад улсын комисс ажиллаж, барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.

ГХБХБГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг Сүхбаатар, Алтанбулаг, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар сумдад ажиллаж

1. Сүхбаатар сумын 8-р багт тоглоомын талбай барих ажилд,
2. Сүхбаатар сумын 8-р баг Буурын голын тохижилтын ажилд улсын комисс ажиллаж барилгын ажлын техникийн бичиг баримтын бүрдлийг хангасны дараа дахин комисс ажиллах шийдвэрийг гаргав.
3. Шаамар сумын 1-р багт баригдсан ундны усны худаг гаргах ажилд,
4. Зүүнбүрэн сумын төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгын гадна фасад засварын ажилд,
5. Зүүнбүрэн суманд “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах” дотор засварын ажилд
6. Түшиг сумын эрүүл мэндийн төвийн дотор засварын ажилд,
7. Түшиг сумын Ар нуга 2-р багийн нутаг дэвсгэрт баригдсан тоглоомын талбай байгуулах ажилд,
8. Алтанбулаг сумын Хувьсгалын музейн дотор засварын ажил, 0.4 кВ-ийн шугамын ажилд,
9. Хушаат суманд хийгдсэн гудамж талбайн гэрэлтүүлгийн ажилд тус тус улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

ГХБХБГ-ын барилга хот байгуулалтын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Ерөө, Хүдэр, Мандал, Баянгол, Сант, Сайхан сумдад ажиллаж

1. Ерөө сумын Тавин багт хийгдсэн гэрэлтүүлэг суурилуулах ажилд,
2. Ерөө сумын Бугант тосгонд гудамжны гэрэлтүүлэг хийх ажилд,
3. Ерөө сумын Бугант тосгонд Бугант худалдааны төв, цагдаагийн байрыг цэвэр, бохир, халаалтын системд холбох ажилд,
4. Хүдэрийн замаас Ерөө сум хүртэлх 3.7 км хатуу хучилттай авто зам барих ажилд,
5. Хүдэр суманд баригдсан 10 ортой эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажилд,

6. Мандал сумын Түнхэл тосгонд баригдсан 10 ортой эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажилд,
7. Мандал сумын Хэрх тосгонд баригдсан соёлын төвийн барилгын их засварын ажилд улсын комисс ажиллаж барилгын засварын ажил дутуу байсан тул дутуу ажлыг хийж гүйцэтгэсний дараа дахин комисс ажиллах шийдвэрийг,
8. Мандал суманд сумын төвийн 5.3 км бохир усны шугам татах ажилд,
9. Мандал сумын Засаг даргын тамгын газрын сантехник засвар, дотор засварын ажилд,
10. Улаанбаатар Дархан чиглэлийн авто замаас Мандал сум хүртэлх авто замтай холбох 29.2 км хатуу хучилттай авто зам тавих ажилд
11. Мандал сумын төвийн авто замын тэмдэг, тэмдэглэгээ суурилуулах ажилд,
12. Сайхан сумын Номгон тосгонд баригдсан цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажилд,
13. Сайхан сумын 24-р цэцэрлэгийн их засварын ажилд улсын комисс ажиллаж ажлын гүйцэтгэл дутуу гэж үзсэн тул дахин комисс ажиллах шийдвэрийг,
14. Орхон сумын соёлын төвийн барилгын их засварын ажилд,
15. Сант суманд цэвэр усны магистрал шугам шинэчлэх ажилд тус тус улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлэв.

5. Орон нутгийн өмчийн талаар:

Олон жил ашиглагдаж элэгдлээ нөхсөн, цаашид ашиглах боломжгүй, ашиглалтгүй байгаа байгууллагуудын үндсэн хөрөнгийг актлах, балансаас баланст шилжүүлэх үндсэн хөрөнгө ашиглалтгүй байгаа тээврийн хэрэгслийг дуудлага худалдаанд оруулах зэрэг албан хүсэлтээр ирсэн бичгийг аймгийн Засаг даргад танилцуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулж ажиллалаа.

Захиалагчаас ирүүлсэн төсвийн дагуу тендер шалгаруулалтыг цаг алдалгүй цахим хэлбэрээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулан www.tender.gov.mn систем болон “Зууны мэдээ”, аймгийн албан ёсны сайтад байршуулж, Сангийн ямаар батлуулан ажиллалаа.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид энэ сард цахимаар 1 удаа хуралдаж 2 асуудал хэлэлцэн газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөө, Алтанбулаг сумын 2021 оны төсвийг баталлаа.

Аймгийн Засаг даргын А/304 тоот захирамж, сумын Засаг даргын А/136 дугаар захирамжийн дагуу “Маскаа зүүе-Гараа угаая” 2 дугаар аяныг 10 дугаар сарын 30-ны өдрөөс 12 дугаар сарыг дуустал зохион байгуулж, аяны хүрээнд сумын онцгой комисс, шуурхай штаб, төр, төсвийн байгууллагыг хамруулан сургалт сурталчилгааны баг томилж өдөр бүр иргэдэд цахимаар заавар, зөвлөмж өгч ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/306 дугаар захирамж, сумын Засаг даргын А/146 дугаар захирамжийн дагуу сумын хэмжээнд “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-т шилжиж 13 үндсэн

чиглэл 24 заалттай төлөвлөгөө батлан ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 226 дугаар тогтоолоор “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэг”-ийн хугацааг 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийг хүртэл сунгасантай холбоотой 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн авто замын хяналтын 2 цэг, сумын төвийн иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах хариуцлагатай жижүүр, сумын шуурхай штаб зэрэг эргүүл жижүүрт төр төсвийн байгууллагын албан хаагчид 75 /давхардсан тоогоор/ 24 цагаар үүрэг гүйцэтгэж байна. 11 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн Алтанбулаг сум бусад сум орон нутгаас 342 иргэнээ хүлээн авч, 274 өрхийн 1016 иргэнийг гэрийн ажиглалтад авч ажиллаж байна.

Сумын Засаг даргын А/185 дугаар “Мал тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллого явуулах хөрөнгө гаргах тухай” захирамжийн хүрээнд ажлын хэсгүүдийг байгуулан, хэрэгжилт 50 хувьтай явагдаж байна.

Аймгийн Онцгой комиссын 11 дүгээр сарын 15-ны өдрийн 184 тоот “Үүрэг хүргүүлэх тухай” албан бичиг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 01 дүгээр “Түлээний модны хуваарь батлах тухай” тогтоол, сумын Засаг даргын А/150 дугаар захирамжийн дагуу мод бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 3 мэргэжлийн байгууллагаар дамжуулан иргэдэд 11 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн галын түлээний гоожин олгох ажлыг зохион байгуулсан. 12 дугаар сарын байдлаар давхардсан тоогоор 2536 м2 галын түлээний гоожин олгогдсон байна. Сумын өвсний нөөцөнд 15 тн 250 кг өвс байна.

Сумын Эрүүл мэндийн төвд түргэвчилсэн оношлуурын шинжилгээний байнгын болон явуулын 3 багийг тус бүр 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж 11 дүгээр сарын 21-ээс 12-р дугаар сарын 21-ийг хүртэл хугацаанд 747 иргэдээс шинжилгээг авч, хариу бүгд сөрөг гарч, зөвлөгөө, зөвлөмжийг өгч ажиллаж байна. Мөн бусад сум орон нутгаас ирсэн 342 иргэн Эрүүл мэндийн төвийн хяналтад байна. Ариутгал халдваргүйжүүлэлтийн багийг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж 11 дүгээр сарын 25-аас эхлэн 7 албан байгууллага, 2 аж ахуй нэгж, 20 хүнсний дэлгүүр, нийтийн эзэмшлийн 64 айлын 10 орц, хонгил, 16 айлын орц сууц, “Алтанплаза” нийтийн байр, хүүхдийн тоглоомын талбай 3, ус түгээх 4 цэгүүдэд нийт 42 байгууллагын 21999 м2 талбайг ариутгалаа. Мөн ажиглалтын байранд байрласан иргэдээс гарсан хогийг ЭМС-ын 505 тоот тушаалын дагуу ЭМТ-ийн эмч нар ангилан ялгаж, хот тохижилт үйлчилгээний машинаар сумын төвийн нэгдсэн хогийн цэгт байрлах эмнэлгийн хог хаягдал устгах цэгт шатааж устгаж байна.

Сумын Ерөнхий боловсролын сургууль Соёлын төвтэй хамтран 12 дугаар сарын 18-28-ны өдрийг хүртэл “Уран жиргээ” уран уншлагын тэмцээнийг 4 насны ангилалд цахимаар зохион байгуулж, тэмцээнд 1-12 дугаар ангийн 91 сурагч оролцож, эхний 3 байрыг шалгарууллаа.

Баруунбүрэн сум:

Тус сард сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурал 1, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 1 удаа хуралдаж дараах шийдвэрүүдийг гаргалаа. Үүнд:

- Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны нийтлэг дэг
- Сумын 2021 оны төсөв
- Сум хөгжүүлэх сангаас 2021 онд олгох зээлийн төсөв, хэмжээ

- 2021 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарь
- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Бодлогын хороодын бүрэлдэхүүн ажиллах журмыг баталлаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны Б/79, Б/80 дугаар захирамжийн дагуу сумын Засаг даргаар буй Ц.Сэлэнгэ томилогдож, ажил хүлээлцэх ажлыг зохион байгууллаа. Иргэдээс сумын Засаг даргад ирүүлсэн 8 өргөдлийг бүртгэл хяналтад хүлээн авч ажиллаж байна.

Төрийн санд 12 дугаар сарын төлөвлөгөөгөөр 238048.6 мян.төгрөг орохоос гүйцэтгэлээр 427837.9 мян.төгрөг орж биелэлт 179.7 хувь, төсөвт байгууллагын өөрийн орлого төлөвлөгөөгөөр 34125.0 мян.төгрөг орохоос гүйцэтгэлээр 33803.6 мян.төгрөг орж биелэлт 99.1 хувь, аймгаас авах санхүүгийн дэмжлэг төлөвлөгөөгөөр 577139.5 мян.төгрөг ирэхээс гүйцэтгэлээр 430379.6 мян.төгрөг ирж биелэлт 74.6 хувьтай байна. Тусгай зориулалтын шилжүүлэгийн байгууллагуудын санхүүжилт төлөвлөгөөгөөр 1582867.1 мян.төгрөг ирэхээс 1582867.1 мян.төгрөг ирж 100 хувь санхүүжигдсэн. ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилт төлөвлөгөөгөөр 193250.7 мян.төгрөг авахаас гүйцэтгэлээр 156598.8 мян.төгрөгийг олгоод байна. ТЗШ-ийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 1649736.3 мян.төгрөг орон нутгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 671164.9 мян.төгрөг буюу нийт төсвийн гүйцэтгэл 2320901.2 мян.төгрөг байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага 158969.3 мян.төгрөг, зээлийн хүүгийн авлага 7580.4 мян.төгрөг нийт 151388.9 мян.төгрөгийн авлагатай байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт төлөвлөгөөгөөр 176911.3 мян.төгрөг авахаас гүйцэтгэлээр 136744.4 мян.төгрөгөөр санхүүжиж гүйцэтгэл 83.6 сая.төгрөг байна.

Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгаар теле хичээл зохион байгуулж байгаатай холбогдон “Теле хичээл” үзэж байгаа суралцагчдын судалгааг авахад 469 сурагч багш нартайгаа холбогдож эргэх холбоотой ажиллаж, 50 сурагч “Теле хичээл”-ээ үзэж чадахгүй байна. “Теле хичээл”-ээ үзэж чадаагүй 50 сурагчийн ар гэрт очих болон утсаар холбогдож шалтгаан нөхцлийг тодруулах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Суралцагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, цахим орчинд соёл түгээх зорилгоор цахим уралдаануудад суралцагчдаа идэвхтэй хамруулахыг зорилго болгон ажиллалаа. Үүнд:

- “Маскаа зүүцгээе гараа угаацгаая” аянд дунд ангийн 246 суралцагч
- Монгол хэл, уран зохиолын багш нарын санаачилсан “Цахим орчинд соёл түгээе” челленжид ахлах ангийн 42 суралцагч
- “Хүчирхийллийн эсрэг хамтдаа” аянд 34 багш нэгдсэн.

1-12-р ангийн суралцагчдыг урамшуулах зорилгоор теле хичээлийг хэрхэн үр дүнтэй үзэж судлан тэмдэглэл хөтөлсөн зэргийг багш нар цахимаар шалган үнэлж дүгнэн, урамшуулах уралдааныг зарлаад байна.

“Олон Улсын Эко сургууль” хөтөлбөрийн онлайн сургалтад удирдах ажилтан 2, багш 2, номын санч 1 нийт 5 хүн хамрагдсан. “Олон Улсын Эко сургууль” хөтөлбөрийн “Мөнгөн гэрэгэ”-ний болзлыг хангаад байна.

Боловсролын тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт 8 багш онлайнаар, 29 багш, удирдах ажилтан цахимаар саналаа өгсөн.

Сэлэнгэ аймгийн Цахим телевизээс зохион явуулсан “Цахимаар гэр гэртээ дасгалаа хийцгээе” аяны уралдаанд амжилттай оролцож:

1. Дунд ангийн насанд:

- 3-р байрыг М.Сэлэнгэ
- Тусгай байранд Б.Итгэлмөнх, Г.Энхжин

2. Ахлах ангийн насанд:

- 3-р байрыг Г.Эрдэнэгүн нар шалгарлаа.

Сумын Эрүүл мэндийн төв нь амбулаторийн үзлэг 135, урьдчилан сэргийлэх үзлэг 81, түргэн тусламжийн дуудлага 92, үүнээс алсын дуудлага 32, ойрын дуудлага 29, эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 17, нас баралт 2, жирэмсний хяналтад 26, шинээр жирэмсний хяналтад орсон 2, жинэлсэн хүүхдийн тоо 39, дархлаажуулалтад нийт 46 хүүхэд хамруулж, 14 эх, нярайг 7 хоног бүр гэрийн эргэлтээр эргэж байна. Мөн өдөр бүр коронавирүсээс хамгаалах хувцас өмсөх, тайлах сургалтыг дотооддоо зохион байгуулан ажиллаж, төр, төсвийн байгууллага, аж ахуй нэгж, хүнсний дэлгүүр, ШТС, худаг, хяналтын цэгт нийт 16850 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийж ажиллалаа.

Голомттой бүс нутаг болох Сүхбаатар суманд дайчлагдан ажиллаж байгаа А.Ууганбаяр, НЭМ-н мэргэжилтэн Х.Бүрэнбаяр, сувилагч С.Алтанзул, Н.Хишигдэлгэр нарын ар гэрт ЭМТ-ийн хамт олноос сэтгэлийн дэм үзүүлж хүн тус бүрт 50000 төгрөгийн хүнсний тусламж үзүүлж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2020 оны “Шуурхай штаб байгуулж, ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А/157 дугаар захирамжаар шуурхай штабын бүрэлдэхүүнийг шинэчлэн, 24 цагийн жижүүрийн хуваарийг батлан захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж тогтмол цагуудад аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Шуурхай штаб, ЗДТГ-ын цэргийн штабуудад тухайн өдрийн мэдээг илтгэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны “Хяналтын цэгт ажиллах жижүүрийн хуваарь батлах тухай” А/158 дугаар захирамжаар төр, төсвийн байгууллагуудаас өгсөн нэрсийн дагуу тус сумын Бургалтайн 2-р багийн нутаг Хөшөөн дэвд байрлах 24 цагийн хяналтын цэгт сумын Онцгой комиссоос ажиллах албан хаагчдын нэрсийг батлан гаргаж 24 цагаар хяналтын цэгт Цагдаагийн хэсгийн төлөөлөгч, цагдаа, Сайхан сумын Онцгой байдлын газрын албан хаагч, сумын ЭМТ-ийн эмч, хариуцлагатай жижүүр гэсэн нийт 5 албан хаагч жижүүрлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/340 тоот захирамжаар сумын хэмжээнд архи, согтууруулах ундааг худалдан борлуулахыг хориглож архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг иргэн, аж ахуйн нэгжүүдийн хүнсний дэлгүүрүүдэд шалгалт зохион байгуулж захирамж танилцуулан, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.

Сумын хэмжээнд 10077 га талбайд улаанбуудай тариалсан боловч цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан 220 га талбай ганд нэрвэгдэж 2147 га талбайн болц оройтож ногоон тэжээлд шилжиж 7710 га талбайгаас 10096 тн улаанбуудай буюу нэгж га талбайгаас 13 цн ургац хураан аваад байна. Тус сумын аж ахуй нэгж, иргэд 2021 оны тариалалтад 605 тн үрийн улаанбуудай, 8700 тн хүнсний улаанбуудайг гурилын үйлдвэрүүд, Тариалан эрхлэгчдийг дэмжих санд

нийлүүлж, 9 иргэн, 13 аж ахуй нэгж урамшуулалд хамрагдах нөхцөл бүрдсэн байна.

Тэжээлд шилжсэн 2147 га талбайгаас 1509 тн ургац хураан авсан. Сумын хэмжээнд нөөцөд 63400 боодол ногоон тэжээл, 2200 боодол боосон солом, 5500 боодол рапсны тэжээл, 50 ширхэг соломны рульон, 6 тн тэжээлийн будаа байна.

12 дугаар сард сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөр 3 иргэн 524050 төгрөгийг төлж барагдуулсан байна.

Баянгол сум:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 209 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/332, сумын Засаг даргын А/276 дүгээр захирамжийн дагуу гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн ажиллалаа.

Сумын хэмжээнд Цагдаагийн хэсэг, ГТУА 40-р анги, Улсын нөөц, хүмүүнлэг тусламжийн анги, Ерөнхий боловсролын сургууль, Баянгол цэцэрлэг, Засаг даргын Тамгын газар хамтран 24 цагийн пост 2 цэгт 4 албан хаагч, хөдөлгөөнт хяналтын цэгт 2 албан хаагч үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Сумын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны А/274 дүгээр захирамжийн дагуу Архи согтууруулах ундаа, худалдах, түүгээр үйлчлэхийг 12 дугаар сарын 25-ны өдрийн 06:00 цаг хүртэл, мөн хугацааг хүртэл хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгж байгууллагын ажиллах цагийн хуваарийг 09:00-19:00 цагийн хооронд байхаар тогтоон хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Сумын нүүрсний нөөц бүрдүүлэх зорилгоор “Шарын гол” ХХК-д хүсэлт гарган 5 вагон нүүрсний нийлүүлэлтийг хийж, онцгой нөхцөлд ажиллаж байгаа 70 төрийн албан хаагч, амьжиргааны түвшин доогуур орлоготой 160 иргэнд хөнгөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулсан.

Сум орон нутгийн зүгээс том оврын автобус гарган Улаанбаатар хотод хөл хорионд байсан 156 иргэд, сумаас Улаанбаатар хотруу явах хүсэлтэй 38 иргэнийг түргэвчилсэн оношилгоонд хамруулан ариутгал алдваргүйтгэлийн дэглэмийг баримтлан зөөвөрлөх ажлыг зохион байгуулж, бусад сум орон нутгаас ирсэн 166 иргэнийг гэрийн тусгаарлалтад байлгаж, хяналт тавин ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны Шуурхай штаб байгуулж ажлын тусгай горимд шилжүүлэх тухай А/254 дүгээр захирамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын байранд шуурхай штабыг байрлуулан 24 цагийн хариуцлагатай жижүүрийг томилж, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг аймгийн Онцгой комисс болон холбогдох байгууллагад 99561654 дугаарын утсаар болон цахимаар Bayangol.ontsgoi.komiss@gmail.com хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв, ЗДТГ-тай хамтран өдөр бүр худалдаа үйлчилгээний 20 цэгийн 1262 м2, төр төсвийн 12 байгууллагын 23866 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийж байна.

12 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар хоол хүнсэнд 2.915.520 төгрөг, шатахуунд 2.298.800 төгрөг, ариутгал хамгааллын хэрэгсэл тусгаарлах байрны бэлтгэх ажилд 4.395.000 төгрөг нийт 9.253.920 төгрөгийн сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулаад байна.

Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 194 дүгээр тогтоолын хавсралтад заагдсан хязгаарлалт тогтоохгүй төрийн

байгууллага, хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны жагсаалтад багтсан шалтгаанаар 11 дүгээр сарын 25-ний өдрөөс эхлэн нийт 204 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2020 оны А/277 тоот “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллого явуулах” тухай захирамжийн дагуу 12 дугаар сарын 17-27-ны өдөр тус тооллогыг зохион байгуулан ажиллалаа.

“Дэлхийн зөн” ОУБ, гэр бүл, хүүхдийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг “Үжин” төв”-тэй хамтран “Байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийг чадваржуулах нь”, “Боловсрол дахь хүүхэд хамгаалал” сэдвээр цахим сургалтыг зохион байгуулж, сургалтад сумын ЗДТГ, ГТУА 40-р анги, ЕБС, 1-р цэцэрлэгийн байгууллагын эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн төлөөлөл, нийт 46 хүнийг хамруулж, хүүхэд хамгааллын чиглэлээр мэдээ мэдээлэл хүргэн ажиллалаа.

Соёлын төвөөс 11 дүгээр сард соёл урлаг, дугуйлан, номын сангийн үйлчилгээний хүрээнд:

1. “Хөдөлгөөн эрүүл мэнд” уриатай нийтийн бүжиг
2. Ахмадын сувиллын амрагчдад нүүдлийн номын сангийн үйлчилгээ
3. Эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлэгчдэд нүүдлийн номын үйлчилгээ
4. Дууны дугуйлан

5. Бүжгийн дугуйлан зэрэг 5 удаагийн арга хэмжээнд 110 хүнийг хамруулан ажилласан.

/Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Дархлаагаа дасгалаар дэмжье” цахим челленжийг бүжгийн дугуйлангаас санаачлан зохион байгуулан ажиллаж байна.

Анхан шатны заах аргын нэгдлээс санаачлан зохион байгуулсан “Хайр түгээе” аяны хүрээнд “Гэртээ өөрийгөө хөгжүүлье”, “Хайртай челленж”, “Зөвд зөв, шударга тоглоцгооё челленж”, “Дархлаатай зөвлөгөө”, “Хүчирхийлэлгүй гэр бүл” фото зургийн уралдаан, “Гацуур модоо урлацгаая” бүтээлийн уралдаан болон “Тог, Цахилгаан Усаа хэмнэцгээе” уриалгад нийт 158 суралцагч нэгдсэн байна.

“Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 өдрийн аян”-ыг 11 дүгээр сарын 25-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд зохин байгуулж, аянаар охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход олон нийтийг татан оролцуулах зорилгоор жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх мэдлэг ойлголтыг цахим хэлбэрээр иргэд, олон нийтэд түгээн ажиллалаа.

Сурагчдын эцэг эхийн санаачилгаар болон “Залуу багш клуб”-ын хамт олны дэмжлэгээр 25 өрхийн 64 суралцагчдад 26 нэр төрлийн 2.734.000 төгрөгийн хүнсний болон түлээ нүүрс өгөх ажлыг зохион байгуулсан. Мөн англи хэлний багш Г.Цэцэгсайхан багш хувиасаа 4 өрхөд тус бүр 6 шуудай мод, 1 шуудай нүүрс хандивлалаа.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах Олон Улсын өдөр”-ийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй 1 сурагчид гарын бэлэг өгсөн.

Хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр доорх зөвлөмжүүдийг боловсруулан цахимаар дамжуулан эцэг эх, асран хамгаалагч, суралцагчдад хүргэсэн.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх	Ахуйн ослоос урьдчилан сэргийлэх	УОК болон ЭМЯ-ы зөвлөмж	Гэрийн нөхцөлд өөрийгөө хэрхэн хөгжүүлэх	Стрессээ тайлах, сэтгэлзүйгээ тайван байлгах чиглэлээр
24	16	17	21	8	2

Ерөнхий боловсролын сургууль 12 дугаар сард нийт 22 удаагийн 48000 м2 талбайг халдваргүйжүүлж ажиллалаа.

Баянгол 1 дүгээр цэцэрлэг 12 дугаар сард Тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжигч, ISO14001 стандартад суурилсан ОУ-ын “Эко-сургууль хөтөлбөр”-ийн 2020 оны “ХҮРЭЛ ГЭРЭГЭ”-ний болзлыг хангаж ажиллалаа.

Бүлгийн багш нар эцэг эхчүүдээ уриалан “Юу байна түүгээрээ тусалъя” аяныг өрнүүлж, зорилтот бүлгийн 14 хүүхдэд хүнс, нүүрс, түлээний нийт 2,730,400 төгрөгийн тусламж, дэмжлэгийг үзүүлж ажилласан.

“Теле хичээл”-ийн бататгал дасгал даалгавар боловсруулан хичээлийн хэрэглэгдэхүүн, шинэ жилийн мэндчилгээ, маскны багцын хамт теле хичээл үзэж чадахгүй байгаа алслагдсан Хараа, Баян, Гонир багийн малчдын 26 хүүхэд, СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа 18 хүүхэд мөн цэцэрлэгийн 279 хүүхдэд хүргэх ажлыг зохион байгуулж байна. Эцэг эхчүүдэд зориулж “Хүүхэд хамгаалал”, “Гэр бүлийн харилцаа үнэ цэнэ”, “Ковид-19” халдвараас урьдчилан сэргийлэх, “Жендэрт суурилсан хүчирхийллийг цэглэе” зэрэг сэдэвт зөвлөгөө, зөвлөмжүүдийг цахим хэлбэрээр хүргэн ажиллалаа. Байгууллагын дэргэдэх хүүхэд хамгааллын багийн хамт олон байгууллагын ажилчдын хүүхдүүдийг витаминжуулах зорилгоор “VITA BANK” аян өрнүүлж дархлааг дэмжлээ.

Эрүүл мэндийн төвд 23 иргэн хэвтэн эмчлүүлж, эрүүл мэндийн даатгалаас санхүүждэг өдрийн эмчилгээнд 29 иргэн эмчлүүлсэн. Түргэн тусламжийн алсын дуудлага 32, ойрын дуудлага 42 ирж анхны тусламж, осол гэмтэл 2, яаралтай түргэн тусламжийг 18 иргэнд тус тус үзүүлсэн. Мандал суманд төрсөн эх 6, шинээр хяналтад орсон жирэмсэн эх 4, хөх, умайн хүзүүний хорт хавдарыг илрүүлэх шинжилгээнд 8, Артерийн гипертензи, чихрийн шижин илрүүлэх шинжилгээнд 21, лабораторийн оношилгоонд 124, Ковид-19 өвчнийг илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд 328, PSR шинжилгээнд 92 иргэнийг тус тус хамруулан ажиллалаа. Нийтийн 359427 м2 талбайд халдваргүйжүүлэлт, Баянгол сумын постоор нэвтэрч буй 284 автомашинд ариутгал хийж, амбулаторийн үзлэг 1248, гэрийн эргэлт 102, жирэмсэн эхийн хяналт 46, 0-5 насны хүүхдийн хяналт 184, 0-2 насны хүүхдийн вакцинжуулалт 58, томуу, томуу төст өвчний эсрэг вакцин 70 иргэнд тус тус хийж, дээд шатлалд 28 иргэнийг 13А маягтаар шилжүүлсэн. Нас баралтын тоо 2 байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын 2010 оны 24/34 дугаар хамтарсан тушаалаар улсын үйлдвэрт тушаасан улаанбуудайн тн тутамд жил бүр урамшуулал олгодог журмын дагуу 14 аж ахуй нэгж, 3 иргэний 5444,08 тн улаан буудайн материалыг цахим хэлбэрээр бүрдүүлж аймгийн ХХААГ-т хүргүүлж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 394 дүгээр тогтоолоор баталсан “Үндэсний боловсруулах арьс шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин,

мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”-ын дагуу 2020 онд арьс ширээ тушаасан малчид, мал бүхий иргэдийн материалыг хүлээн авч ажиллаж байна.

Зам тээврийн сайд, Хүнс хөдөө аж ахуйн сайдын 2020 оны А/225, А/379 тоот Мал, мах, хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийг нэгдсэн зохион байгуулалттайгаар аймаг, сум, хот хооронд тээвэрлэх ажлыг зохион байгуулах тухай хамтарсан тушаал гарсныг сумын хэмжээнд сурталчлан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Аймгийн ХХААГ-ын даргын 2020 оны 590 тоот мэдэгдэл, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын дагуу сумын хүн амын тоонд тулгуурлан өргөн хэрэглээний гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийг 7 хоног бүр тодорхойлж, бүтээгдэхүүний хүрэлцээг тогтвортой байлгах, нөөц бүрдүүлэлт, дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавих, өргөн хэрэглээний гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг 7 хоногийн даваа, пүрэв гариг бүр авч аймгийн ХХААГ-т хүргүүлэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны А/276 тоот “А/274 дүгээр захирамжид нэмэлт өөрчлөлт оруулж, хугацаа сунгах тухай” захирамжийг хүнсний худалдаа эрхлэгч 23 иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

2020 онд Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 11 иргэний 12 сарын зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 5.7 сая төгрөгийг сангийн дансанд төвлөрүүлээд байна.

11 дүгээр сард ажлын байрны захиалга ирүүлсэн 9 иргэн, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу ажил идэвхтэй хайгч иргэдээс зуучлах ажлыг зохион байгуулж 2 иргэнийг сул чөлөөтэй ажлын байранд, 7 иргэнийг ажлын шинэ байранд зуучилж нийт 9 иргэнийг байнгын ажлын байраар хангасан. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр 12 дугаар сард Эрүүл мэндийн төв, ЗДТГ, “Майнд тэч” зэрэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу ажил идэвхтэй хайгч иргэдээс зуучлах ажлыг зохион байгуулж 4 иргэнийг сул чөлөөтэй ажлын байранд зуучилж байнгын ажлын байраар хангасан.

Халамжийн тэтгэврийг 100 иргэнд 31124.3 мян.төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 85 иргэнд 8562.4 мян.төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 18 иргэнд 5012.5 мян.төгрөг, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмжийг 45 иргэнд 1667.4 мян.төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 259 иргэнд 12576.1 мян.төгрөг, 3 болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг 1 иргэнд 429.1 мян.төгрөг, алдарт эхийн одонгийн мөнгөн тэтгэмжийг 2 иргэнд 200.0 мян.төгрөг, ахмад настны хөнгөлөлтийг 7 иргэнд 5770.0 мян.төгрөг, гавъяат цолтон ахмад настан 1 иргэнд 150.0 мян.төгрөгийн тусламж, хөнгөлөлт, ХБИ-ийн хөнгөлөлтийг 17 иргэнд 1940.0 мян.төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн мөнгөн урамшуулалыг 7 иргэнд 302.4 мян.төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 163 иргэнд, 3176.0 мян.төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг дэмжлэг үзүүлж нийт 698 иргэнд **70910.2** мян.төгрөгийг олгож “Нийгмийн халамжийн тухай хууль”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”, “Ахмад настны тухай хууль”, “ЭОХӨТЭЭТ олгох тухай хууль”, МУЗГ-ын 17, 340, 25,96, 167-р тоот тогтоол бусад холбогдох хуулийн

заалтуудын хүрээнд зөвлөгөө, зөвлөмж, мэдээлэл өгч ажиллалаа. Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж байнгын асаргааны мөнгөн тэтгэмжинд 5 иргэнийг хамруулахаар шийдвэрлэсэн.

2020 онд сумын Орон нутгийн орлогын жилийн төлөвлөгөө 194.8 сая төгрөг батлагдсанаас жилийн эцсийн байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр 237.4 сая төгрөг буюу оруулахаар төлөвлөснөөс ХБГ-ээр 222.6 сая төгрөг буюу 121.9 хувийн биелэлттэй байна.

Аймгийн санхүүгийн дэмжлэгээр 759.6 сая төгрөг авснаас 656.5 сая төгрөгийн татаас авч төсвийн байгууллагуудын санхүүжилтийн гүйцэтгэлд үндэслэн 100 хувь санхүүжилтийг олгосон.

Төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог цаг тухай бүрт нь анхан шатны баримтыг үндэслэн 1996 удаагийн гүйлгээгээр 3,807,623,850.9 төгрөгийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэсэн. Төсвийн байгууллагуудын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн 100 хувь олгосон бөгөөд хугацаа хэтэрсэн өглөг, авлага үүсгээгүй.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5 ажил хийхээр төлөвлөснөөс 4 ажлыг 100 хувь гүйцэтгэж, 1 ажил санхүүжилтээс шалтгаалан хийгдээгүй. Дотоод хяналтын чиглэлээр 2020 оны төлөвлөгөөний дагуу ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв, Спорт цогцолбор зэрэг байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан.

Тус сард шинэ төрсөн 7, шинээр гэр бүл болсон 1, нас барсан 2, шилжин ирсэн 17, иргэний үнэмлэх 16 нас хүрч шинээр авах 2, 45 насны сунгалт 1, иргэний үнэмлэх дахинаар 3 иргэн авахаар тус тус захиалж бүртгүүлсэн. Иргэний үнэмлэхийн лавлагаа 4, төрсний лавлагаа 12, оршин суух хаягийн лавлагаа 1 тус тус олгож ажиллалаа.

Баянгол сумын Гонир 3 дугаар багт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Бороо гоулд” ХХК, “Тод-Ундрага” ХХК, “Сонор трейд” ХХК-иудын 2020 оны “Байгаль орчны менежмент төлөвлөгөө”-ний биелэлтийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг цахимаар хэлэлцэж, үнэлгээг дүгнэж, 2021 онд хэрэгжүүлэх ажлын саналыг хэлэлцсэн.

Ерөө сум:

Тус сард сумын Засаг даргын А захирамж 23, Б захирамж 4, Засаг даргын албан тоот 18, Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал 3, Б тушаал 3 гарч, дээд байгууллагаас 66 бичиг ирж, 17 хариутай бичиг бүртгэж хугацаанд нь хариуг хүргүүлсэн 8, хугацаа болоогүй 5, хугацаа хоцорч явсан 4 бичиг, шуурхай бичиг 2 ирж шийдвэрлэн ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 178 тоот тогтоол, аймгийн Засаг даргын А/306, А/310, А/311, А/324, А/332 захирамж, Сэлэнгэ аймгийн Онцгой комиссын 05 тогтоолын дагуу зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын болон зарим төрлийн үйл ажиллагааг түр зогсоож цагийн хязгаарлалт тогтоож, бүх нийтийн бэлэн байдлын горимыг хэрэгжүүлж захирамжаар гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр 06:00 цаг хүртэл хугацаагаар сунгаж нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу тусгаарлах байр, өдөр бүр сумын хэмжээнд эргүүл хяналтыг 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр, шуурхай штабыг 24 цагаар, сумын гарах хэсэгт цагдаагийн постыг ажиллуулж байна.

Аймгийн Засаг даргын А/340 дүгээр захирамжаар “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” Сүхбаатар, Алтанбулаг сумаас бусад суманд хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хэвийн явуулж байна.

Аймгийн Засаг даргын А/335 дугаар захирамжаар Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллогыг зохион байгуулж, 24 чиглэлд 92 хүний бүрэлдэхүүнтэйгээр 1067 өрхийг хамруулан тооллоо. Дүн нэгтгэлийн ажлыг хийж байна.

Сумын онцгой байдлын шийдвэрээр Хүдэр, Бугант тосгонд байгаа самарчид болон Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг, бусад аймаг сумдын хүмүүст дамжин өнгөрөх хойд замын пост дээр түргэвчилсэн оношлуураар 800 хүнд шинжилгээ хийсэн байна.

Орон нутгийн төсвийн орлого 2112698.9 мян.төгрөгийн орлого орохоос 2449222.1 мян.төгрөгийн татварын болон татварын бус орлого орж орлогын төлөвлөгөө 116.0 хувиар биелсэн дүнтэй байна.

Хөл хорионы нөхцөлд сурагчдыг хөгжүүлэх ажлын хүрээнд Бага ангийн багш нар сурагчдын дунд шүлэг цээжлэх, уран унших, үсэглэлийн хаад, сэтгэх чадварын бодлого бодох, зураг зурах, будах, цаасан урлал, наамал, спорт аяганы өрөлт, гэр барих, буулгах ёсонд суралцах зэрэг 10 төрлийн хөгжүүлэх ажиллагааг цахимаар явуулж 310 сурагч хөгжиж байна. Дунд ангийн багш нар 6-9-р ангийн сурагчдын дунд илтгэх урлаг, цаасан нугалаа, зураг урлал, сэтгэх чадварын зэрэг 4 төрлийн хөгжүүлэх ажиллагаа, цахимаар хичээллүүлж 96 хүүхэд, хичээлээр хөгжүүлэх чиглэлээр математикийн онлайн дугуйлан хичээллэж 25 сурагч, “Үндэсний бичиг”-ийн цахим дугуйланд ба, б ангийн 21 сурагч сурч хөгжиж байна. Ахлах ангийн сурагчдын дунд мэргэжлийн багш нар монгол хэл, математик, нийгмийн ухааны, түүхийн, химийн сонгон судлах хичээлийн групп чат үүсгэн онолын мэдлэг, тест, зөвлөгөөг өдөр бүр өгөхийн зэрэгцээ google meet, zoom зэрэг онлайн апп ашиглан дасгал, хугацаат даалгаварыг өгч 114 сурагч хичээлээр хөгжиж байна.

Коронавирусийн тархалтыг таслан зогсоох, тэмцэх, хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улсын Онцгой комиссоос бүх нийтийн хөл хорионы дэглэм тогтоонсонтой холбогдуулан сумын Онцгой комиссын зүгээс зорилтот 23 өрхөд хүнс тэжээлийн тусламж олгоод байна.

Ойгоос мод бэлтгэх эрхийн бичгийг давхардсан тоогоор 204 иргэнд олгож 264 м3 түлээний мод бэлтгэгдсэн байна. Хууль бус мод бэлтгэж байгаатай холбогдуулан 1, 2-р багийн нутаг дэвсгэрт 2 удаа хяналт шалгалтын ажлыг хийж, хяналт шалгалтаар зохих зөвшөөрөлгүйгээр, эрхийн бичигт заасан нөхцөл болзолыг зөрчсөн 13 зөрчил илэрч холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Мөн “Хүзүүвчний өвөр”гэх газар 79-79 ДАА KLUGER маркийн авто машинтай 4 иргэн цооног гарган тороор загас барьж байсныг холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

“Өвлийн идэш” арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хот, Дархан-Уул аймагт амьдардаг 89 иргэний 16.2 идэшний махыг хүргэх ажлыг зохион байгууллаа. Мал амьтан, тэдгээрийн түүхий эд, бүтээгдэхүүний цахим гарал үүслийн гэрчилгээ 195, таримал ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээг 102 иргэнд олгож ажиллалаа.

Жавхлант сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуралдаж 2020 оны төсвийн гүйцэтгэл, 2021 оны төсөв, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэлэлцэн баталлаа.

Сумын Засаг даргын 2020 оны А/170 тоот захирамжийн дагуу жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулж, дүн нэгтгэлийн ажлыг хийж байна.

Сумын Засаг даргын 2020 оны 01 дүгээр албан даалгавар, сумын Засаг даргын 2020 оны “Хариуцлагатай эргүүл жижүүрийг томилон ажиллуулах тухай” А/21 дугаар захирамжийн дагуу сумын албан байгууллагуудын албан хаагчид эргүүл жижүүрийн үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын 12 дугаар сарын 07-ны өдрийн “Иргэдийн зорчих хөдөлгөөнийг шуурхай зохион байгуулах тухай” 01 дүгээр албан даалгаврыг нийтэд мэдээлж, бусад сум орон нутаг руу явах иргэдийн судалгаанд бүртгэлтэй 24 иргэний 22 иргэнээс Эрүүл мэндийн төвд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авч, Улаанбаатар хот болон бусад аймаг сумруу 17 иргэний гарах зөвшөөрлийг олгож ажилласан. Уг албан даалгаврыг үндэслэн сумын Онцгой комиссын 2020 оны “Иргэдийн зорчих хөдөлгөөнийг шуурхай зохион байгуулах тухай” 02 дугаар албан даалгаврыг гаргаж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн сумын Засаг даргын 2020 оны А/174 тоот захирамжаар согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 01-р сарын 01-ний өдрийн 06:00 цаг хүртэл түр хугацаагаар хориглосон тухай сумын архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрөлтэй 4 аж ахуйн нэгж, дэлгүүрүүд болон иргэдэд мэдээлж, хэрэгжилтийг ханган, хяналт тавин ажиллаж байна.

Эрүүл мэндийн төв нь 12 дугаар сард 285 хүнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж, зөвөлгөө өгч, түргэвчилсэн оношлуураар гэрийн тусгаарлалтын 22, өөр орон нутагруу зорчих 48, онцгой комиссын 19, эрүүл мэндийн төвийн албан хаагч 13, нийт 102 иргэнийг шинжилгээнд хамруулж, хариу нь сөрөг гарсан.

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол, хүнс болон бага ангийн суралцагчдын үдийн цайнд зарцуулахаар нөөцөлсөн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүнс тэжээлийн дутагдалд орох эрсдэлтэй зорилтот бүлгийн 7 өрхийн /1-6 насны 1 хүүхдэд 91.420 мян.төгрөг, 7-14 насны 4 хүүхдэд 566.200 мян.төгрөг, 15-18 насны 2 хүүхдэд 331.340 мян.төгрөг нийт 988.960 мян.төгрөг/-ийн хүнсний багц, зорилтот бүлгийн өрхийн цэцэрлэгийн 1-5 настай 10 хүүхдэд 110200 мян.төгрөгийн хүнсний багц бүхий нийт 1.102.000 төгрөгийн хүнсний багцыг хүргэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Өвөлжилт хүндэрсэн Баянхонгор аймгийн онцгой комисст тус сумын “Хурниад ХХК”-ий бэлтгэсэн өвс, тэжээлийг нийлүүлэх ажлыг зохион байгуулж 594 боодол урлондсон тэжээл, 298 тн өвсийг Өмнөговь, Өвөрхангай, Дундговь аймгуудад нийлүүлээд байна.

Зүүнбүрэн сум:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит бус хуралдааны шийдвэрээр цахилгааны үнийг тэглэсэнтэй холбогдуулан сумын Засаг даргаас “Цахилгааны монтаж хэрэглээнд үзлэг хийх ажлын хэсэг”-ийг байгуулан Жаргалант 1 дүгээр багийн нутаг “Бойны довны КТП-215”-аас тэжээлтэй 6 өрх, “Гахайн байрны АТП 126”-аас тэжээлтэй 5 өрх, Бэлчир 2 дугаар багийн

“Төвийн хэсгийн АТП-125”-аас тэжээлтэй 2 айл өрхүүдийн 52 иргэнд эрчим хүчний ачааллыг нэмэгдүүлэхгүй, нэг уртасгагчинд олон залгуур залгахгүй байх, цахилгаан монтажны аюулгүй, бүрэн бүтэн байдлыг хангах талаар зөвлөгөө, гарын авлага өгч ажиллалаа.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, сэрэмжлүүлгийг урсдаг зар болон *Zuunburen zar*, Зүүнбүрэн сумын онцгой комисс цахим хаягаар дамжуулан иргэдэд тогтмол сурталчлан, хүргэн ажиллаж байна.

“Иргэний бүртгэлийн тухай хууль”-ийн дагуу төрсний бүртгэл 1, гэрлэсний бүртгэл 1, нас барсны бүртгэл 4, шилжин ирсэн бүртгэл 3, биеийн давцахгүй өгөгдлийн бүртгэл 9, иргэний үнэмлэх дахин авах бүртгэл 1, иргэний үнэмлэх олголтын бүртгэл 12, лавлагаа олголт 9, гэрчилгээ дахин олголт 4 нийт 41 бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүллээ.

2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжих “Малын хөлийн албан татварын тухай” хуулийг *Zuunburen zdtg* цахим хаягаар дамжуулан иргэдэд сурталчлан хүргэж байна.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй “Зөв зөв шударга зөв” нөлөөллийн аяны хүрээнд 5 ширхэг зурагт сурталчилгаа, 3 ширхэг видео, Жендерийн үндэсний хорооноос зохион байгуулж буй “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” аяны хүрээнд 11 зурагт сурталчилгаа, 4 видеог иргэдэд сурталчлан ажиллалаа. “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх аян”-ы хүрээнд зохион байгуулж байгаа “Яг одоо цэглэе” аянд 16 багш зурагт сурталчилгаа хийж, сургуулийн цахим хуудас, ангийн болон эцэг эхийн группт байршууллаа.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хөл хорио тогтоосонтой холбогдуулан эцэг, эх нь хөл хорионд орсон 12 хүүхдийн судалгааг гарган холбогдох ажил арга хэмжээг авч ажиллаж байна.

Боловсрол шинжлэх ухааны яамны 2020 оны 162 дугаар тушаалын дагуу Ерөнхий боловсролын сургуулиас 1.607.450 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүний дэмжлэг, тусламжийг шаардлагатай 37 өрхөд үзүүлсэн.

“Олон улсын Эко хөтөлбөр”-ийн ахисан шатны 3 дахь удаагийн “YRE” Байгаль орчны залуу сурвалжлагч, “LEAF”, “Ойн талаар суралцахуй сургалт”-д хамрагдан сумын Ерөнхий боловсролын сургууль “Мөнгөн гэрэгэ”-ний эзэн боллоо.

“Идэш” арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотруу 55 иргэний 5тн мах, 1 тн сүү цагаан идээг тээвэрлэлээ.

Аймаг, сумын Засаг даргын 2020 оны “Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллогыг зохион байгуулах тухай” захирамжийн дагуу 12 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн тоолох ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

“Энхбүрэн сүрэг”, “Оюут сүрэг” МЭҮН-ийн үйл ажиллагаанд хяналт тавьж 68 өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрийг баталгаажуулан “Мал амьтаны эрүүл мэндийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалтыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Мандал сум:

Монгол Улсын Засгийн газар, Улс, аймгийн Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор сумын Онцгой комисс 31 удаа хуралдаж, 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/223, “Сумын онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх

тухай” А/224, “Архи, согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчилэхийг хориглох тухай” А/225, “А/224 тоот захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/226, “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжлүүлэх тухай” А/228, “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/242 тоот захирамжийг гарган хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны “Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үед сумын Гамшгаас хамгаалах шуурхай штабын ажиллах журам батлах тухай” А/231, “Сумын ажиллагааны баг байгуулах тухай” А/232, “Санхүү, хангалт, үйлчилгээний баг байгуулах тухай” А/233, “Хариу арга хэмжээний баг байгуулах тухай” А/234, Бодлого төлөвлөлт, мэдээллийн баг байгуулах тухай” А/235 дугаар захирамжуудыг гаргаж, сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийн мэргэжлийн анги албадуудын бэлтгэл бэлэн байдлыг шуурхай хангуулан, үүрэгжүүлж ажиллалаа.

Мандал сумын нутаг дэвсгэрт “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын тохиолдол илэрсэн үеийн тактик ажиллагааны төлөвлөгөө, Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үе дэх сумын нутаг дэвсгэрт коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг чангатгах, эрчимжүүлэх” төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумын Засаг даргын Тамгын газарт 24 цагийн ажиллагаатай шуурхай штаб ажиллаж, шуурхай штабын 70367010 утсанд 4305 дуудлага ирсэн ба хуш модны самар түүх зорилгоор болон бусад шалтгаанаар хөл хорионд саатсан 1035 иргэнийг бүртгэлжүүлэн 3270 иргэнд нөхцөл байдлын мэдээ өгч ажиллалаа.

Улс, аймаг, сумын Онцгой комисс, шуурхай штабаас гарсан мэдээ, мэдээлэл, коронавируст халдвар “covid-19”-өөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг видео мэдээлэл 18, видео сэрэмжлүүлэг 10, фото мэдээлэл сэрэмжлүүлэг 42 бэлтгэн хүргэж, орон нутгийн “Мандал” телевиз видео мэдээ 17, фото мэдээлэл 23 бэлтгэн телевизийн эфир, Фейсбүүк пейжүүдээр мэдээлж байна. Мөн 6 төрлийн сэрэмжлүүлэг бэлтгэн Нэгдсэн эмнэлэг, Онцгой байдлын алба, ЗДТГ тусгай авто машины чанга яригч болон худалдааны гудамжинд байрлах чанга яригчаар иргэдэд тогтмол мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Бүх нийтийн хөл хорионы үед СӨБ-ын боловсрол олгох ажлыг эрчимжүүлэх зорилгоор цахим, теле хичээлд хамрагдах боломжгүй хүүхдүүдэд 7-14 хоногийн сургалтын агуулгыг багтаасан хэвлэмэл материал тараан ажиллалаа.

Хамтарсан багийн үндэсний сургагч багш доктурат Д.Ундармаагаар “Байгууллагын эцэг эхийн зөвлөл”-ийн гишүүдийг чадавхжуулах, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх 1 өдрийн цахим сургалтыг зохион байгуулж нийт 21 байгууллагын 50 гишүүнийг хамрууллаа.

“Хүүхэд эцэг эхийн хяналтгүйгээр олон нийтийн цахим сүлжээг ашигласнаар хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй” тухай сэрэмжлүүлэг, “Монголын өв соёлыг илтгэсэн үндэсний тоглоомыг тоглох арга зүй”-н мэдээ мэдээлэл, “Цахим номын сан” үйлчилгээг 89 удаагийн давтамжтайгаар нийтийн номын сангийн цахим хуудсаар иргэдэд хүргэн ажиллаж байна.

Эрсдэлд өртөж болзошгүй 119 хүүхэд /эцэг эх нь самарт явсан, өөр орон нутагт хөл хорионд орсон 28 өрхийн 62 хүүхэд, хараа хяналтгүй 140 хүүхэд ... г.м/-ийн судалгаа мэдээллийг гаргаж, хяналт тавьж ажиллаж байна.

Монгол Улсын Шадар сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтран баталсан 2020 оны 188 тоот түр журмын дагуу ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай, дотуур байр, цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсэнд зарцуулахаар нөөцөлж, төлбөрийг нь бүрэн барагдуулсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг боловсролын байгууллагын гаргасан судалгааны дагуу цэцэрлэг, сургуулийн насны хүүхэдтэй, хүнсний дэмжлэг үзүүлэх шаардлагатай зорилтот бүлгийн 193 өрхөд олголоо.

Мэргэжлийн зэрэг авах шалгуур, стандартыг хангасан сургууль, цэцэрлэгийн 4 удирдлагад “Тэргүүлэх” зэрэг олголоо.

Сумын хэмжээнд коронавирус /КОВИД-19/-ыг илрүүлэх шинжилгээнд 5276 өрхийн 21571 иргэнийг хамруулж, шинжилгээнд хамрагдсан иргэдээс 3 эерэг тохиолдол бүртгэгдэж ХӨСҮТ-рүү шилжүүлснээс нэг иргэн эдгэрч орон нутагтаа ирсэн тул дээд шатны байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн дагуу хяналт тавин ажиллаж байна.

Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотойгоор хүнс тэжээлийн хомстолд орсон эмзэг бүлгийн өрхийн судалгааг гарган сумын Засаг даргын нөөц болон иргэд, ААНБ-аас ирүүлсэн хандиваар нийт 361 өрхөд 16.782.0 төгрөгийн тусламж үзүүлэн ажиллалаа. Үүнд:

- УИХ гишүүн Ч. Ундрам 90 өрхөд 3.942.000 төгрөгийн хүнсний багц
- Сумын Засаг даргын нөөцөөс 200 өрхөд 10.000.000 төгрөгийн хүнсний тусламж
- Мод бэлтгэл, өрхийн тариаланч 3 ААНБ, 3 иргэн 30 өрхөд 1.500.000 төгрөгийн хүнсний тусламж
- “Сая сарнай” ЗБН 20 өрхөд 500.000 мян.төгрөгийн хүнсний тусламж
- Улаан загалмайн нийгэмлэг 21 өрхөд 840.000 төгрөг
- Зүүнхараа Хүүхдийн ордон “ХАЙРААР ДҮҮРЭН БОГЦ” аян зарлаж 60 өрхөд тус тус тусламж, дэмжлэг үзүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/335, сумын Засаг даргын А/247 тоот захирамжийн дагуу 2020 оны жилийн эцсийн мал тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллогыг сумын хэмжээнд зохион байгуулан ажиллалаа.

Мал амьтан, тэдгээрийн түүхий эд бүтээгдэхүүний цахим гарал үүслийн гэрчилгээ 125, таримал ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэл 10 иргэнд олгож ажиллалаа.

2020 оны улаанбуудайн урамшуулалд 11 аж ахуйн нэгжийг хамрууллаа.

Сум хөгжүүлэх сангаас зээл авсан чанаргүй 8 зээлдэгч иргэний 33 сая төгрөгийн төлөлтийг санд төвлөрүүлж ажиллалаа.

- Улсын төсвийн 20.888.888.888 төгрөгийн хөрөнгөөр “Замын битум” ХХК-ий хийж гүйцэтгэсэн 51 ширхэг гүүр хоолойтой, цементээр бэхжүүлсэн суурьтай, 4 см суурь, 3 см өнгө хучилттай Улаанбаатар-Дархан чиглэлийн /А0401/ авто замаас Мандал сум хүртэлх 28.9 км авто замын барилга,

- Улсын төвийн 2.207.245.425 төгрөгийн хөрөнгөөр “Алтайн үндэс констракшн” ХХК-ий гүйцэтгэсэн Сумын төвд 5.3 км бохирын шугам, насос станцын барилга,

- Улсын төсвийн 1.050.000.000 төгрөгийн хөрөнгөөр Түнхэл тосгонд “Хайспийдгрупп” ХХК-ий барьсан 10 ортой эмнэлгийн барилга тус тус ашиглалтад орлоо.

Мод бэлтгэх эрхийн бичгийг 6 ААНБ-д хэрэглээний 1680.6м3, 283 иргэнд түлээний 2469 м3 олгож, хөл хорионы үед ард иргэдэд түлээний хомстол үүсгэхгүй байх зорилгоор мод бэлтгэлийн 6 аж ахуй нэгж байгууллага 100м3 түлээг 53 айлд хөнгөлөлттэй үнээр, 9 иргэнд үнэ төлбөргүй түлээ олгох ажлыг зохин байгуулж ажиллалаа. Мод бэлтгэлийн талбай тусгаарлалтын ажлыг ашиглалтын огтлолт 18 га, цэвэрлэгээний огтлолт 132 га, цэвэрлэгээний ажил 65 га буюу нийт 215 га талбайд хийлээ.

2020 онд сумын “Галсан булагийн эх”, “Саалинч”, “Бэр цагаан”, “Шар шургааг”, “Улаан шаварт”, “Тайлжийн эх”, “Зүр хүзүү”, “Гурантай”, “Буянт”, “Барчгар”, “Хандгайт” орчмын ашиглалтын бүсийн ойн сангаас 3850.7 тн самар бэлтгэх нөөц тогтоогдсон. Дээрх нөөцийг үндэслэн сумын ИТХ-ын 2020 оны 36, 97 тоот тогтоолуудаар 3845 тн самар үйлдвэрлэлийн зориулалтаар, 5 тн самар ахуйн зориулалтаар бэлтгэхээр шийдвэрлэсний дагуу 23 аж ахуйн нэгж байгууллагатай үйлдвэрлэлийн зориулалтаар 3145 тн самар бэлтгэх гэрээ байгууллаа. 12 сарын байдлаар үйлдвэрлэлийн зориулалтаар 1725 тн, ахуйн зориулалтаар 525 кг нийт 1725.525 тн самар бэлтгэх зөвшөөрөл олгож, 1.3 тэрбум төгрөгийг, хуш модны самар бэлтгэхээр зөвшөөрөл авсан 136 тээврийн хэрэгслийн жолоочтой гэрээ байгуулж, 1576 иргэнд ойд зорчих тасалбар олгож 1.794.000 төгрөгийн төлбөр хураан авч төрийн санд төвлөрүүлж ажиллалаа.

Орхон сум:

“Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 тоот тогтоол, улс, аймгийн Онцгой комиссоос өгч буй үүрэг чиглэлийн дагуу дараах ажил арга хэмжээг авч ажиллалаа: Үүнд:

- Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Орхон сумын нутаг дэвсгэрт коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг чангатгах, эрчимжүүлэх төлөвлөгөө-г /халдварын түвшин хяналтаас гарсан буюу “Улаан түвшин”/ гаргалаа.

- Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд /Covid-19/ халдварт цар тахлын /өмнөх үед ажиллах, цар тахлын үед ажиллах, дараах үед ажиллах/ үед хэрхэн ажиллах талаар тодотгол хийж аймгийн Онцгой байдлын газрын холбогдох албан тушаалтанд хүргүүлэн батлуулсан.

- Сумын шуурхай штабын ажиллах хуваарь, төрийн албан хаагчдын хяналтын цэгт ажиллах хуваарь, байгууллагуудын эргүүл жижүүрээр ажиллах хуваариудыг тус тус батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн тусгаарлах байрны бэлтгэл бэлэн байдалтай холбоотой тооцоо судалгааг /7, 14, 21, 90 хоногоор/ гарган ажиллаж байна.

Орхон сумаас мод бэлтгэл 76 айл өрхийн 304 м3, Баруунбүрэн сумаас 321 өрх мод бэлтгэхээр хүсэлтээ өгч давхардсан тоогоор 109 иргэн 436 м3 мод бэлтгээд байна. Сумын төвд 5 иргэн 35 тн нүүрсийг жижиглэнгээр худалдаалж байна.

99964613, 99411946 дугааруудыг 24 цагаар ажиллуулж, дуудлага хүлээн авч, мэдээ мэдээлэл дамжуулан, иргэдэд зөвлөгөө, зөвлөмж өгөн ажиллаж байна.

Цахим орчинд улс, аймаг, сумын Онцгой комиссын гаргасан шийдвэр болон мэдээллүүд, шуурхай штабын бүрэлдэхүүний утасны жагсаалт, хуваарийг байршуулан иргэдийг мэдээ, мэдээллийг түргэн шуурхай авах боломжоор ханган ажиллаж байна.

Хүнсний хомсдол үүсэх эрсдэлт нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан аймгийн Онцгой комиссын зөвшөөрөөлөөр Дархан-Уул аймгаас хүнсний дэлгүүрүүдийг хүнс тээвэрлэх, мөн сумын эмийн эргэлтийн сангийн эм тарианы хангалтыг тус аймгаас бэлтгэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хүнсний худалдаа үйлчилгээ, түгээлтийн үйл ажиллагааг хэвийн явуулах хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа хүнсний 8 дэлгүүрийн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг 7 хоногт 2 удаа тогмтол гарган ажиллаж байна.

Улаанбуудайн урамшуулалд хамрагдахаар хүсэлт ирүүлсэн 22 ААН 3 иргэний материалыг бүрдүүлэн ХХААГ-т хүргүүлэн ажилласан.

Улс, аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу бусад аймаг, сумдаас иргэдээ татан авах ажлыг 12 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн нийт 173 иргэнийг татан авч ажилласан.

Сумын Эрүүл мэндийн төвөөс Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Маскаа зүүцгээе-гараа угаая” 2-р аяныг зохион байгуулж, аяны хүрээнд “Яагаад заавал амны хаалт зүүх ёстой вэ?”, “Гараа хэрхэн угаах вэ?”, “Нэг удаагийн амны хаалтыг устгах зөвлөмж”, “Ажлын байран дээр анхаарах зөвлөмж”-ийг цахим орчинд байршуулж ажиллалаа. Ерөнхий боловсролын сургуулийн 11-р ангийн сурагчдаас “Маскаа зүүж, гараа угааж, коронаг дарцгаая” уриаг гаргаж, уриалгын дагуу дуу зохион дуулж цахим сүлжээгээр сурталчлан оролцлоо. “Гараа тогтмол угааж, гэр бүлээ хайрлая” аян зарлаж, хүүхдүүдийн гар угааж буй бичлэг, гар зургийн уралдаанаас шилдэг 2 бүтээлийг шалгаруулан гарын бэлгээр шагнаж урамшуулсан.

“Хүүхэд хамгаалал” аяны хүрээнд сумын ГХУССЗ-ийн ажлын хэсэгтэй хамтран эрүүл мэндийн шторк 1, осол аюулгүйн шторк 1 бэлтгэн сумын фэйсбүүк хуудсаар дамжуулан иргэдэд мэдээлэл, уриалгын хүргэн ажиллаж байна.

Төрийн болон төрийн бус байгууллага, ААН-үүдээс 13000 ширхэг маск хандивт цугларч, иргэдэд 1000 ширхэг маскыг тарааж ажиллалаа.

Гамшгаас хамгаалах Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан ЕБС-иас зорилтот бүлгийн 10 өрхийн хүүхдүүдэд 300.000 төгрөгийн хүнс тэжээлийн тусламж, 1-р цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөлөөс 6 өрхийн 8 хүүхдэд ахуйн хэрэглээний тусламж, мөн иргэн Н.Уртнасангийн гэр бүлээс эрсдэлт бүлгийн өрх А.Отгонбаярын 50.000 төгрөгийн хүнс тэжээлийн тусламжийг үзүүлсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 тогтоолоор улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан нийтийн эзэмшлийн гудамж, талбай, худалдаа үйлчилгээний газруудаар эргүүл жижүүрийн ажлыг хийж, байнгын хяналтын постод 24 цагийн үүрэг, шуурхай штабын жижүүрийг тогтмол ажиллуулж байна.

Сайхан сумын Номгон 3 дугаар багийн нутаг “Хөтөл нарс” гэх газраас иргэн Б.Төрбат нь хууль бусаар зөвшөөрөлгүй мод бэлтгэсэн зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан “Зөрчлийн тухай хууль”-ийн дагуу 300.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажиллалаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Баруунбүрэн сумын “Шинэ орос хийц” ХХК-ий ойн мэргэжлийн байгууллагаас мод бэлтгэсэн 81

тээврийн хэрэгслийн 324 м3 модны тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж нийслэл, аймаг, сумдын орох гарах хөдөлгөөн хаасантай холбогдуулан МЭТ, МЭҮН-д мал амьтны гарал үүслийн гэрчилгээг цагийн хязгаарлалт тавихгүй, хүнд сурталгүй түргэн шуурхай бичиж баталгаажуулан олгож байна. Аймгийн Засаг даргын 2020 оны “Хүнсний хангамж, нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах тухай” А/309 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах, “Өвлийн идэш бэлтгэх, хүнсний хангамж, Мал мах аян”-ы хүрээнд 12 дугаар сарын 7, 8-ны өдрүүдэд Улаанбаатар хот, Дархан-Уул аймагт амьдарч байгаа иргэддээ өвлийн идэш хүргэх ажлыг ЗДТГ-аас зохион байгуулж, 3024 кг үхрийн мах, 158 кг адууны мах, 935 кг хонины мах, 18300 кг ямааны мах, 10 л сүү, 10кг ааруул, 10 кг аарцанд гарал үүслийн гэрчилгээг бичиж баталгаажуулан олгож ажилласан.

Орон нутгийн байгууллагуудын төсвийн санхүүжилтийн зарцуулалтын гүйлгээг батлагдсан төсвийн дагуу анхан шатны баримтыг үндэслэн нийт 27912646.25 төгрөгийн гүйлгээг хийсэн.

/Covid-19/ цар тахлын улмаас Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг Боловсрол, шинжлэх ухааны яамны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/146 тушаалын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулах хугацаанд бага ангийн 11 судлагдахууны 227 цагийн “теле хичээл”-ийг 131 сурагчаас 130 сурагч, дунд ахлах анги 424 цагийн “теле хичээл”-ийг 132 сурагчаас 130 сурагч үзэж, хамрагдалт 98.8 хувьтай байна.

1-р цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаанд “Дунд”, “Ахлах”, “Бэлтгэл” гурван бүлэгт 2-5 насны 95 хүүхэд бүртгэлтэйгээс 94 хүүхдэдтэй үйл ажиллагааг явуулж байсан ба “Теле хичээл” буюу цахим сургалтад 2-5 насны 81 хүүхэд буюу 86.1 хувь нь тасралтгүй хамрагдаж байна.

Мөн цэцэрлэгийн хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхэд, 1 өндөр настан иргэнд хоол хүнсний багц бүхий хүнсний дэмжлэг, Орхон сумын иргэн Ж.Ариунбатын эмчилгээний зардалд цэцэрлэгийн хамт олны зүгээс 100.000 төгрөгийн тусламж, хоол хүнсний дэмжлэг шаардлагатай 8 хүүхдэд тус бүр нь 30.000 төгрөгийн, зорилтот бүлгийн дэмжлэг шаардлагатай 9 хүүхдэд хүнсний дэмжлэгийг нийт 19 хүүхэд, 2 том хүнд үзүүлэн ажилласан.

Орхонтуул сүм:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, 2020 оны Улсын Онцгой комиссын А/214, аймгийн Засаг даргын А/306 тоот захирамжийн дагуу цар тахлаас хүн амыг урьчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээнд аймаг сумаас гарах, орох чиглэлд иргэд, зорчигч тээврийн хэсэгслийн хөдөлгөөн болон бүх шатны боловсролын байгууллагын хичээл сургалт, соёл урлаг, спортын уралдаан тэмцээний үйл ажиллагааг зогсоох шийдвэрийн дагуу сумын Онцгой комисс шийдвэр гарган хэрэгжилтийг ханган, хяналт тавин ажиллаж байна.

Сумын хэмжээнд коронавируст /Covid-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээнүүдийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, шуурхай штабын бүрэлдэхүүнийг 24 цагаар жижүүрлүүлэн ажиллуулж, иргэд, олон нийтэд зөвлөмж, мэдээллийг тогтмол хүргэн, иргэн бүр хариуцлагатай байхыг уриалан ажиллаж байна. Мөн автомашин,

иргэдийн хөдөлгөөнийг түр хязгаарласантай холбогдуулан сумын төвд цагдаагийн хяналтын цэгийг тогтоож, шуурхай штабын жижүүрийг 24 цагаар ажиллуулан постоор нэвтрэн гарч буй тээврийн хэрэгсэл, иргэдийг бүртгэлжүүлэн ажиллаж байна.

Иргэд, олон нийтэд энэхүү цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээллийг тогтмол өгч шаардлагагүй тохиолдолд гэрээсээ гаралгүй, гэр, өрөө тасалгаандаа ариутгал халдваргүйжүүлэлтийг сайтар хийж, биеийн дархлаагаа дэмжих хоол хүнсийг тогтмол хэрэглэж, улс, аймаг, сумын Онцгой комиссын шийдвэр, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яамнаас гаргасан заавар, зөвлөмжийг хэрэгжүүлэн өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах талаар уриалгыг цахим орчноор дамжуулан хүргэж байна.

Шуурхай штабын жижүүрүүд хуваарийн дагуу сумын төв болон орон сууц, гэр хорооллын зарлалын самбарт цаг үеийн мэдээллийг байршуулан иргэдийг Онцын шаардлагагүй тохиолдолд гэрээсээ гарахгүй байхыг зөвлөн ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын 2020 оны 01 тоот албан даалгаврын дагуу сумын хэмжээнд иргэдийн орох, гарах хөдөлгөөнийг зохион байгуулан суманд ирж, гарч буй иргэдийн PCR шинжилгээний хариу, бичиг баримтыг хянан шалгах “Шалган нэвтрүүлэх баг”-ийг тогтмол ажиллуулан Дархан-Уул аймаг болон Улаанбаатар хотоос суманд ирэх иргэдийн судалгааг гарган иргэдийг татан авах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Дархан-Уул аймгаас нийтийн тээврээр 1 удаа 28 иргэн, Улаанбаатар хотоос 2 удаа 71 иргэн нийт 3 удаагийн татан авалтаар нийтийн тээврээр 99 иргэн, 61 хувийн тээврийн хэрэгслээр 172 иргэн, 163 өрхийн 271 иргэнийг татан авч хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны “Хүнсний хангамж, нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах тухай” А/309 тоот захирамжийн хэрэгжилтийг хангах, “Өвлийн идэш бэлтгэх, хүнсний хангамж, мал-мах аян”-ы хүрээнд сумын ЗДТГ-аас Дархан-Уул аймаг руу идэш явуулах малчин, мал бүхий иргэдийг бүртгэлжүүлэн 28 иргэний 2 тн махыг Дархан-Уул аймгийн постод хүргэх ажлыг зохион байгууллаа. Улаанбаатар хотоос идэшээ авахаар ирэх хөдөлгөөнийг хаах зорилгоор Улаанбаатар хотод байгаа 32 иргэний 7 тн өвлийн идэш, мах, хүнсний бүтээгдэхүүнийг хүргэж өгөх ажлыг зохион байгуулж ажилласан.

Дархан-Уул аймгаас гурилын хэрэгцээгээ хангахаар “Өгөөж чанар” ХХК-иас 12 тн гурил авч 7 хүнсний дэлгүүр, 1 талх, нарийн боовны цехэд, мөн Улаанбаатар төмөр замын харьяа “Дархан” худалдааны төвийн салбар “Ган зам сүлжээ” дэлгүүрт 20.4 тн гурилын нийлүүлэлтийг татан авах ажлуудыг зохион байгууллаа.

Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөрийг сурталчилах зорилгоор Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй “Авлига ашиг сонирхолын зөрчилгүй хамт олон аян”-ыг сумын хэмжээнд зохион байгуулж, иргэдэд зориулсан авлигын хор аюулыг олон нийтэд тайлбарлан таниулах зорилгоор сумын төр, төсвийн байгууллагуудын ажилчдад “Авлига гэж юу вэ”?, “Авлигын хор уршиг, авлигын эсрэг хууль тогтоомж”-ийг сурталчилан видео контент, шторкыг Орхонтуул ЗДТГ, Рашаант тосгоны цахим хуудсуудаар дамжуулан мэдээллийг хүргэж, 5 байгууллагын 121 ажилтан, албан хаагчдад энэ тухай ойлголт, мэдээлэлийг хүргэн ажилласан. Сумын төр, төсвийн 5

байгууллагын 62 албан хаагч, иргэдэд “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Зөрчлийн тухай хууль”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-иар сургалт зохион байгуулж мэдээлэл хүргэн ажилласан.

Тус сард шинэ төрөлт 5, нас баралт 4, иргэний үнэмлэх олголт 2, лавлагаа 22, сунгалт 2, олголт 1, дахинаар 1, газар 6 нийт 49 иргэнийг онлайн санд бүртгэж ажилласан.

Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж “Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үүүлэх журам”-ыг тогтмолжуулан шинэ төрсөн 4 хүүхдэд хүндэтгэл үзүүллээ.

12 дугаар сард нийгмийн даатгалын төвлөрсөн санд 52877.7 мян.төгрөг, эрүүл мэндийн даатгалын санд 473.8 мян.төгрөг, нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 3 малчин иргэн, 4 ажилгүй иргэн, тэтгэвэр 518 иргэнд 25610.7 мян.төгрөг, жирэмсэн, амаржсаны тэтгэмж 2 иргэнд 2600.5 мян.төгрөг, ажилгүйдлийн тэтгэмж 4 иргэнд 2242.9 мян.төгрөгийг тус тус олгож ажиллалаа.

2020 оны батлагдсан төлөвлөгөөгөөр улсын төсөвт 39.800.0 мян.төгрөг, аймгийн төсөвт 200.420.0 мян.төгрөг, сумын төсөвт 41.982.0 мян.төгрөг нийт 282.202.0 мян.төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсан. Үүнээс 12 дугаар сарын 25-ны байдлаар өссөн дүнгээр улсад 33813.5 мян.төгрөг төвлөрч 85 хувь, аймагт 196322.6 мян.төгрөг буюу 98 хувь, сумын төсөвт 78974.1 мян.төгрөг төвлөрүүлэн 188.1 хувь нийт 309110.2 мян.төгрөг төсөвт төвлөрч 110 хувийн биелэлттэй байна.

Нийгмийн халамжийн сангийн халамжийн тэтгэвэрийг 33 иргэнд 9600.0 мян.төгрөг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 28 иргэнд 2619.5 мян.төгрөгийг олгоод байна. Халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр 6 төрлийн үйлчилгээг цахимаар бүртгэж, жирэмсэн эхийн тэтгэмжид 1 эхийг шинээр хамруулж, нийт 9 эхэд 340.0 мян.төгрөг, цалинтай ээжийн тэтгэмжид 3 эхийг шинээр хамруулж, 71 эхэд 3576.6 мян.төгрөг, 0-18 насны 3-с дээш хүүхэдтэй өрх толгойлсон 1 эхийг шинээр хамруулж, 4 эхэд 1549.0 мян.төгрөг, Алдарт эхийн 1-р одонгийн тэтгэмж 2 эхэд 200.0 мян.төгрөг, Алдар цолтой 2 ахмад настанд 300.0 мян.төгрөг, ахмад настан 5 иргэнд шүд хийлгэсний хөнгөлөлт 590.0 мян.төгрөг, 1 иргэнд түлээ нүүрсний хөнгөлөлт 140.0 мян.төгрөг шинээр төрсөн 1 хүүхдийн бүртгэл хийж, өрхийн судалгаанд хамруулж, хүүхдийн мөнгийг олгож ажиллалаа. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 5 өрхийн 37 иргэнд 656.0 мян.төгрөгийн хүнсний 10 нэр төрлийн бүтээгдхүүнийг олгосон.

УОК-оос бүх нийтийг хамарсан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан нийгмийн бодлогын чиглэлээр шаардлагатай бүх судалгааг шинэчилэн, хөл хорионы улмаас эцэг эх нь нийслэл болон өөр аймаг суманд хорионд орсон хүүхдүүдийн судлагааг гаргасан. Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа эцэг эх нь хорионд орсон 8 өрхийн хүүхдүүдэд маск, гар ариутгагч болон хүнсний тусламж үзүүлж, сумын хэмжээнд амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой 5 өрхөд хүнс тэжээлийн тусламж үзүүллээ. Сумын болон Рашаант тосгоны Эрүүл мэндийн төвөөс бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд сумын ЗДТГ-ын буудалд 6 ортой, Рашаант тосгоны Соёлын төвд 8 ортой, ЭМТ-д 2 ортой, тусгаарлах байрыг тус тус сэргээн тохижуулж, 22 байгууллагын 33472 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийж ажиллалаа.

12 дугаар сарын 01-25-ныг хүртлэх хугацаанд тус сумын тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжилт авдаг 6 байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 408.738.614.2 төгрөгийн төлбөр тооцоог, анхан шатны бичиг баримтыг үндэслэн 260 төлбөрийн хүсэлтээр 407 удаагийн хандалтаар ЗГУМСистемд ажил гүйлгээг шивж баталгаажуулж ажиллалаа.

Сайхан сум:

Улаанбаатар хот болон бусад аймаг сум руу зорчих иргэд, аж ахуй нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдаас 1436 шинжилгээ хийж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын А/309 тоот захирамжийн дагуу “Өвлийн идэш” арга хэмжээ зохион байгуулж 12-р сард сумын 751 өрх өвлийн идшээ бэлтгээд байна.

Баруунбүрэн сумаас 111 машин 444 м3 түлээний мод бэлтгэгдсэн байна.

“Хүчирхийллийг яг одоо цэглэе” аянд 14 төрийн байгууллагын ажилтан албан хаагчдыг идэвхитэй хамруулан 50 наалттай хуудас, 180 тараах материалыг иргэдэд цахим хэлбэрээр хүргэн ажиллаж байна.

Улсын хэмжээнд өрнөж буй “Манай хашааг авраач” зорилтот аянд “Хөтөл бетон хийц” үйлдвэрийн хамт олон нэгдэж Гавшгай 2-р багийн 1 өрхийг сонгон хашааны нүүрэн талыг евро бетон хашаа болгон засварлаж тохижууллаа.

Байгаль орчны хяналтын чиглэлээр сум дундын цагдаагийн хэлтэстэй хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 3 удаа зохион байгуулж, уг ажлын хүрээнд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй ан амьтан агнасан 2 иргэнд, газрын хэвлий ашигласан 1 иргэнд Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль, шийтгэлийн арга хэмжээг авч 550.000 төгрөгийг сумын хүү торгуулын дансанд төвлөрүүлж ажилласан.

Төсвийн байгууллагуудын төсвийн хуваарлалтын дагуу санхүүжилт олгогдож сарын төлбөр тооцооны 5163 ширхэг баримтаар 9.016.148.363.08 төгрөгийн гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна.

Тус суманд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 21 аж ахуйн нэгж, байгууллага, 8 иргэнулаанбуудайн үнийн урамшуулалд хамрагдах шаардлагыг хангаж байна.

“Малын тоо толгойн албан татварын тухай хууль” батлагдаж, хэрэгжих болсонтой холбоотойгоор тус хуулийн талаарх санал асуулга, хэлэлцүүлгийг цахим болон утсаар холбогдож мэдээлэл өгч ажиллаж байна.

Санал асуулгад нийт малчин өрхийн 56 хувь хамрагдаж, цахим санал асуулгад 27 малчин мал бүхий иргэд, утсаар 281 малчин мал бүхий иргэнд хуулийн талаар мэдээлэл өгч ажиллалаа.

Баг	1-р баг	2-р баг	3-р баг	Нийт
Малчин, Мал бүхий өрхийн тоо	48	77	373	498
Хамрагдсан	36	41	204	281
Хувь	75	53.2	54.7	56.4

Сант сум:

Сумын Засаг даргын “Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллого явуулах тухай” А/164 дүгээр захирамжийн дагуу ажлын хэсэг сумын нутаг дэвсгэрийн 16 чиглэлд 12 машин, 60 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, тооллогын

ажилд 1.442.900 төгрөгийг зарцуулсан. 2020 оны жилийн эцсийн мал тооллогын урьдчилсан дүнгээр адуу 4616, үхэр 11515, хонь 40542, ямаа 32920 бүгд 89593 толгой мал тоологдсон байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдаанаар сумын 2021 оны төсвийг хэлэлцэж 2364776.7 мян.төгрөгөөр батлагдлаа. Үүнээс орон нутгийн татварын орлого 59330.0 мян.төгрөг, аймгаас авах санхүүгийн дэмжлэг 696478.1 мян.төгрөг, төсвийн өөрийн орлого 500.0 мян.төгрөг, 2020 оны татварын давсан орлого 14153.7 мян.төгрөг, зарцуулаагүй мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 30636.1 мян.төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын санхүүгийн дэмжлэг 1179622.7 мян.төгрөгөөр тус тус батлагдсан байна.

2021 онд суманд аймгийн хөрөнгө оруулалтын 276.9 сая төгрөгөөр 5 ажил үйлчилгээ, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт 107.1 сая төгрөгөөр 8 ажил үйлчилгээ хийгдэнэ.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд шаардлагатай хөрөнгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж 6822.1 мян.төгрөгийг зарцуулаад байна.

Үүнд:

- Халдвар хамгааллын 100 ширхэг хувцас авахад зориулж 1700.0 мян.төгрөг
- Хяналтын постны түлээ, хоол хүнсний зардалд 717.4 мян.төгрөг
- Тусгаарлах байрны тохижилт, гэрэл цахилгаан татах, халдваргүйтэл, ариутгал, бусад зардалд 816.7 мян.төгрөг
- Нэг удаагийн маск худалдан авахад 1580.0 мян.төгрөг
- Муур нохой устгахад 1268.0 мян.төгрөг
- Халуун хэмжигч авахад 140.0 мян.төгрөг
- Халдварын голомтонд ажилласан эмч нарын урамшуулалд 600.0 мян.төгрөг тус тус зарцуулагдсан байна.

Сумын Онцгой комиссоос иргэдийн өвлийн хүнс бэлтгэлийг хангуулах зорилгоор "Идэш" арга хэмжээг нэгдсэн журмаар зохион байгуулж,

- Улаанбаатар хот руу 8 удаагийн тээвэрлэлтээр 99 өрхийн 23.2 тн мах
- Дархан-Уул аймаг руу 10 удаагийн тээвэрлэлтээр 42 өрхийн 10.2 тн мах
- Орхон аймаг руу 3 удаагийн тээвэрлэлтээр 9 өрхийн 2.5 тн мах
- Сүхбаатар сум руу 1 удаагийн тээвэрлэлтээр 8 өрхийн 1.2 тн мах нийтдээ 22 удаагийн тээвэрлэлтээр 37.1 тонн мах, 3 тн сүүг 198 иргэнд тээвэрлэж хүргэсэн байна. 1 удаагийн тээвэрлэлтээр 6 өрхийн 1.7 тн махыг зах зээлд борлуулсан.

2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс “Малын тоо толгойн албан татварын тухай хууль” хэрэгжиж байгаатай холбогдуулан сумын мал аж ахуйн өнөөгийн байдал, мал үржлийн бодлого, хууль тогтоомжийг сурталчилж, малчин болон мал бүхий 345 өрхөд гарын авлага тарааж, “Малын тоо толгойн албан татварын тухай хууль”, “Авлигын эсрэг хууль”, “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Эрүүл мэндийн тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай”, “Нийгмийн даатгалын тухай хууль”, “Хүүхэд хамгааллын хууль, тогтоомж”-ийг 2 удаагийн давтамжтайгаар цахим орчинд сурталчилан ажиллалаа.

“Яг одоо хүчирхийллийг цэглэе” аянд төсөвт байгууллагууд болон “Эмэгтэйчүүдийн холбоо” нэгдэж жендэрт суурилсан хүчирхийллийн бүхий л хэлбэрийг таслан зогсоох тэмцэлд дуу хоолойгоо нэгтгэж байна. Хүчирхийллийг цаг алдалгүй таслан зогсооход чиглэсэн уриалга зөвлөмж, мэдээлэл, шторкыг цахим орчинд 12 удаагийн давтамжтайгаар байршуулж, аяны хүрээнд сумын ИТХ-ын төлөөлөгчдийн тусламж дэмжлэгээр зорилтот 8 өрхийн хүүхдэд 232.000 мян.төгрөгийн хүнсний багц, ахмад настан 1, ХБИ 1, амьжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой 4 нийт 6 өрхөд 250.000 мян.төгрөгийн түлээний модны тусламж үзүүлж ажиллалаа.

Сумын Засаг даргын Тамгын газар, 1-р цэцэрлэг, ЕБС-ийн эцэг эхийн зөвлөлөөс 4 өрхийн 12 хүүхдэд 265.000 мян.төгрөгийн хүнсний тусламж, мөнгөн дэмжлэгийг, мөн хүүхэд ивээн тэтгэх хөтөлбөрт бүртгэлтэй зорилтот өрхийн 2 хүүхдэд “Дэлхийн Зөн”ОУБ-ын Сэлэнгэ ОНХ-өөс 426.000 мян.төгрөгийн хүнсний тусламж үзүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын А/304 дүгээр захирамж “Маскаа зүүе, гараа угаая” 2 дугаар аяны хүрээнд “Коронавируст халдвар (COVID-19)-аас сэргийлье”, “Маскаа зүүе, гараа угаая”, “Маск хэрхэн зөв зүүх вэ?” зурагт хуудас, зөвлөмжийг үйлчилгээний газрууд, багийн мэдээллийн самбаруудад байршуулж, 8 удаагийн давтамжтайгаар цахим орчинд 2 шторк, 6 зөвлөмжийг иргэдэд хүргэн ажиллаж байна.

Суманд төсөвт байгууллага 5, Эмийн сан 2, Уурын зуух 3, ШТС 1, “Дархан-Сэлэнгэ цахилгаан түгээх шүлжээ” ХК-ий салбар 1, Хаан банк, Төрийн банк, хүнсний дэлгүүр 6, ундны ус түгээх цэг 2, талхны цех 1 тус тус ажиллаж, албан байгууллагын ажилтан, албан хаагчдын маскны хэрэглээ 100 хувь, мөн үйлчилгээний байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийн маскны хэрэглээ 100 хувьтай хэрэгжиж байна.

Сумын Ерөнхий боловсролын сургууль “Тогтвортой хөгжлийн бодлого” төслийн хүрээнд явагдаж байгаа “Олон улсын Эко-сургууль” хөтөлбөрийн “Мөнгөн гэрэгэ”-ний болзол хангасан сургуулиар шалгарсан байна.

Сүхбаатар сүм:

Сүхбаатар сумаас ХӨСҮТ, Цэргийн төв эмнэлэгт эмчлэгдэж байгаад эдгэрч гэртээ ирсэн 181 иргэнийг гэрийн тусгаарлалтад авч багийн Засаг дарга нар хяналт тавин ажиллаж байна.

Тус сумын нутаг дэвсгэрт Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын тохиолдолыг бууруулах “Нэг өрх-нэг иргэн” PSR шинжилгээ авах ажлыг зохион байгуулж 5825 өрх хамрагдахаас 4680 өрх буюу 89.7 хувьтай хамрагдлаа.

“Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үе дэх сумын нутаг дэвсгэрт коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг чангатгах, эрчимжүүлэх төлөвлөгөө”-г боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Коронавирус /Ковид-19/ өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс шаардлагатай 20 төрлийн тоон судалгааг тухай бүр шинэчилэн гаргаж холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байна. Мөн иргэдэд Ковид-19 цар тахал, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн байгаатай холбогдуулан гаргасан аймаг, сумын Засаг дарга нарын захирамж, албан бичиг, мэдээ мэдээлэл, коронавирус өвчнөөс

урьдчилан сэргийлэх тухай сэрэмжлүүлэг мэдээ, зурагт хуудас 58, “Маск нэг удаагийн хувцас хэрэглэл зөв өмсөж тайлах”, зөвлөмж, зөвлөгөө, видео контентыг сум, багууд, харъяа төр төсвийн байгууллагын цахим хуудсуудаар тухай бүр иргэдэд хүргэн ажиллаж байна.

Коронавирус цар тахлын үед хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан сумын 8 багийн зорилтот буюу АБТДО-той, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй буюу хүүхэдтэй, хүнсний хомсдолд өртөж болзошгүй 950 гаруй өрхөд /давхардсан тоогоор/ сумын Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж, байгууллага /төрийн болон төрийн бус байгууллагууд/ сайн дураараа туслалцаа үзүүлж буй иргэд хамтран хүнсний болон эд материал, түлээ нүүрсний туслалцаа үзүүлж ажиллалаа.

Хүнсний дэлгүүрүүдийн худалдаалж буй гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үлдэгдэл, татан авалт, үнийн зохиомол хөөрөгдлөөс урьдчилан сэргийлэх, архи согтууруулах ундаа худалдаж буй эсэхэд хяналт шалгалтыг 12 удаагийн 150 гаруй аж ахуйн нэгж, хүнсний дэлгүүрүүдэд холбогдох заавар, зөвлөмжийг өгч ажиллаж байна.

Сумын хэмжээнд түлшний мод бэлтгэх талбайгүйн улмаас иргэдийн түлшний модны хангалтыг Түшиг, Хүдэр сумдаас бэлтгэж байна. Нийт 1536 өрхөд 1010 м3 түлшний модыг түгээлтээр олгоод байна.

12 дугаар сард хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан “Сүхбаатар хөгжил-тохижилт” ОНӨААТҮГ 126 удаагийн таталтаар 745 тн хог, хаягдлыг тээвэрлэж төв хогийн цэгт буулгасан.

Сумын хэмжээнд 8 баг дээр нийт 27 худаг ажиллаж иргэдэд ус түгээлтийн үйл ажиллагааг хүргэж, 7 хоног бүр мэргэжлийн байгууллагаар ариутгал халдваргүйтгэлийг хийлгэж байна.

Япон улсын Шизико мужийн хамтын ажиллагааны хүрээнд тус мужаас манай суманд төмс, хүнсний ногооны зориулалтын зоорь барих хүсэлтэй байгаагаар илэрхийлж албан бичиг ирүүлсэн тул холбогдох судалгаануудыг гарган хүргүүлж ажиллалаа.

Улсын төсвийн 350.0 сая төгрөгийн хөрөнгөөр “Цагаан эрэг 2-р багийн байр, өрхийн эрүүл мэндийн төв, цагдаагийн хэсэг бүхий шинэ барилгын ажлыг “Содон Сод Оюу” ХХК 100 хувь хийж гүйцэтгэсэн.

Түшиг сум:

Сумын Засаг даргын 2020 оны А/111 тоот захирамжаар Засаг даргын үйл ажиллагааг боловсруулах ажлын хэсгийг байгуулж, иргэдээс санал авах ажил, арга хэмжээг зохион байгуулж байна. Сумын Засаг даргын 2020 оны А/113 тоот захирамжаар “Мал тэжээвэр амьтад хашаа худгийн ээлжит тооллого”-ыг зохион байгуулж нийт 10 хэсэгт 22 албан хаагч ажиллалаа.

Ковид-19 цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд Шуурхай штабыг 24 цагаар ажиллуулж, Үзүүр хошууны хяналтын цэгт байнгын жижүүрийг томилж, нийт 45 төрийн албан хаагч ажиллаж байна. Улаанбаатар хот бусад суурин газруудаас орон нутгийн иргэдээ татан авах ажлыг зохион байгуулж, Улаанбаатар хотоос 186, Дархан-Уул аймгаас 44, Сүхбаатар сумаас 27, бусад суурин газраас 17 иргэнээ авч, гэрийн тусгаарлалтад шилжүүлж, дэглэмийн хугацаанд хяналт тавин ажиллаж байна.

Цар тахлын үед хүнс тэжээлийн дутагдалд орж болзошгүй нийт 45 өрхөд хүнсний багц арга хэмжээг хэрэгжүүлж, 1 өрхөд 94.000 мян.төгрөгийн хүнсний тусламжийг үзүүллээ.

Эрүүл мэндийн төвөөс өдөр бүр 1100-2500 м² талбайд, мөн хүнсний зориулалтаар ирсэн бараа бүтээгдэхүүнд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж байна. Орон нутгийн хэмжээнд тусгаарлах байрыг бэлтгэж, эм эмнэлгийн хэрэгсэл, халдвар хамгааллын хувцасны нөөцийг бүрдүүлсэн.

2021 онд бэлтгэх хэрэглээний болон түлээний модны хуваарийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулж, ойн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гарсан дүрэм, журам, 2020 оны мод бэлтгэл, хяналт шалгалтын талаар мэдээлэл бэлтгэн танилцууллаа.

Сүхбаатар сумын 1200 м³, Зүүнбүрэн сумын 450 м³ түлээний мод бэлтгэл, тээвэрлэлтийг мэргэжлийн байгууллагаар бэлтгүүлэн, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, “Шинэ бадрах ХХК”-ий 2 талбай, “Мойлт нуга” ХХК-ий 1 талбайд мод бэлтгэх талбай тусгаарлалтын ажил хийлгүүлэн хэрэглээний зориулалттай мод бэлтгэл, тээвэрлэлтэд хяналт тавин ажилласан.

Түшиг сумаас Улаанбаатар хотын болон бусад аймаг, сумын иргэдэд “Өвлийн идэш” хүргэх ажлыг шуурхай зохион байгуулж, нийт 89 иргэний 13.6 тн махыг Улаанбаатар хотруу, Дархан-Уул аймгийн 7 өрхийн өрхийн 85 кг мах болон Сүхбаатар сумын 17 өрхийн 2.5 тн махыг хүргэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

12 дугаар сард: Шинээр төрсөн 3, эцэг тогтоолт 1, иргэний үнэмлэх олголт 3, нас барсны бүртгэл 1, иргэний үнэмлэхний сунгалт 2, шилжин ирсэн 5 иргэн бүртгэж, 18 иргэнд гэр бүлийн байдлын бүртгэлийг хийж, нэг иргэнд лавлагаа олгож, “Иргэний бүртгэлийн тухай хууль”, холбогдох хууль, дүрмээр зөвлөгөө өгч ажиллалаа.

Эрүүл мэндийн төвөөр тус сард нийт 123 хүн анхан шатны үзлэг шинжилгээнд хамрагдсанаас урьдчилан сэргийлэх үзлэг 62, гэрийн идэвхитэй эргэлт 146 буюу 38 хүн, түргэн тусламжийн дуудлага 41, үүнээс алсын дуудлага 8, ойрын дуудлага 33 иргэнд үйлчилсэн. Эмнэлэгт 38 хүнийг хэвтэн эмчилж, 2 эх төрснөөс сумандаа 1, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад 1 эхийг төрүүлсэн. Шинээр жирэмсний хяналтад 3 эхийг авч, эхний 3 сартай хяналт 12, нийт 15 эх хяналтад байна. Осол гэмтлийн өвчлөл 2 тохиолдол бүртгэгдэж, товлотл дархлаажуулалтад 12 хүүхэд хамрагдаж дархлаажуулалтын дараах урвал хүндрэл гараагүй.

Бага боловсролын мэргэжилтэн П. Мягмарсүрэн бага боловсролын багш нарт 4 удаагийн онлайн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 32 багш хамрагдаж мэргэжил арга зүйн зөвлөгөө авсан.

Сургуулийн удирдлагууд бүх багш нартай ажил хэргийн онлайн уулзалтыг зохион байгуулж, цаг үеийн ажил, сурагчдын теле хичээл үзэж байгаа байдалд дүн шинжилгээ хийж, 1-р улирлын дүн гаргахад бэлтгэх, сурагчдын хичээл хийх идэвх оролцоог нэмэгдүүлэх арга зүйг хэлэлцсэн.

Боловсрол, соёл, урлагийн газраас зохион байгуулж буй “Гэртээ өөрийгөө хөгжүүлье” аянд 1а ангийн сурагч Т.Хүсэлбаяр, 3а ангийн сурагч Б.Тамир, З.Ундрал, Б.Чингүүн, Н.Намуундарь, 4а ангийн сурагч М. Цэнгүүн нар оролцсон.

“Маскаа зүүе, гараа угаая” 2-р аяны уриалгыг олон нийтэд цахимаар сурталчлан, аянд сургуулийн 25 багш, 21 ажилтан идэвхтэй оролцлоо.

БШУЯ, Боловсролын Үнэлгээний Төвөөс хамтран явуулсан “Ерөнхий боловсролын сургуульд хэрэгжиж буй сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, сурагчдын мэдлэг, чадварыг бодитой үнэлэх, мэдээлэл цуглуулах, боловсруулах түүнд дүн шинжилгээ хийх, үр дүнд суурилсан үйл ажиллагааг төлөвлөх, багшлахуй болон суралцахуйд чиглэсэн шийдвэр гаргах арга зүй”-д суралцах 2 өдрийн цахим сургалтад захирал, сургалтын менежерийн 3 хамрагдлаа.

Монгол хэл, уран зохиолын багш Л.Атарцэцэг нь дугуйлангийн сурагчдын хамтаар “Түшигийн хүүхдүүд-Түшигийн ирээдүй” сонинг 2 дахь удаагаа эрхлэн гаргалаа. 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хооронд 5 долоо хоногийн хугацаанд Боловсролын хүрээлэнгээс 10-12-р ангийн сурагчдад зориулсан онлайн хичээлийг arlus.mn \Мэдлэгийн үйлдвэр\ ашиглан улсын хэмжээнд зохион байгуулахаар болж Монгол хэл, уран зохиолын багш Л. Атарцэцэг, түүх нийгмийн ухааны багш Н.Буянтогтох нар Теле хичээлийг заах эрх аваад байна.

Хушаат сум:

Сумын хэмжээнд эргүүл, хяналт шалгалтын ажилд 42 албан хаагчийг томилон ажиллуулж, сумын төвийн хэв журмыг сахиулах ажлыг гүйцэтгэж байна.

Тус сард сумын хэмжээнд 258 хүн гаднаас ирж, 138 өрхийн 547 хүн тусгаарлагдснаас 25-ны өдөр 112 өрхийн 443 иргэн тусгаарлалтаас гарч 26 өрхийн 96 иргэн тусгаарлалтад байна.

Хушаат сумын Онцгой комиссоос авч хэрэгжүүлэх коронавируст халдварын цар тахлын хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй холбогдуулан нийтийн эзэмшлийн зам талбай, худалдаа үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, ШТС-ын гадна талбай, төсвийн байгуулагуудыг 45 хоногийн хугацаанд 65381.6 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийгээд байна.

11 дүгээр сарын 12-ноос хойш 84 удаа аймгийн Онцгой Комисс, Мэргэжлийн Хяналтын Газар, аймгийн Онцгой байдлын газар, ЗДТГ-ын Цэргийн хэлтэст холбогдох мэдээ, мэдээллийн хүргүүлэн ажиллалаа.

Төрийн үйлчилгээний операторын системийн үйл ажиллагаа хэвийн үргэлжилж 7 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн иргэдээс 172 хүсэлт ирснээс 153 үйлчилгээг шийдвэрлэн олгож, лавлагаа үйлчилгээг давхардсан тоогоор 153 иргэнд үзүүлж ажиллалаа.

Авлигатай Тэмцэх газраас ирүүлсэн авлигаас урьдчилан сэргийлэх 5 шторк, 4 төрлийн зурагт хуудас, мөн “АТГ-ын олон нийтийн төв” пэйж хуудсанд нэгдэн “Зөв зөвд шударга Зөв соён гэрээрүүлэх аян”-ы “Том толгойтын адал явдал”, Монгол Улсын гавьяат зүтэлтэн Аюулгүй байдлын ухааны доктор PhDЖ.Цогтсугарын “Шударга байх гэдгийг та юу гэж ойлгодог вэ?” зэрэг мэдээллийг сумын ЗДТГ-ын Сэлэнгэ Хушаат fb хуудаст байрлуулж, 622 хүнд хүргэж ажиллалаа.

“Улсын бүртгэлийн тухай хууль”, “Иргэний бүртгэлийн тухай хууль” бусад холбогдох хууль журмын хүрээнд төрөлт 3, нас баралт 3, шилжилт 2, гэрлэлт 1, иргэний үнэмлэх авах 20, төрсний гэрчилгээ 7, дахин олголт 9, гэрлэсний гэрчилгээ нийт 46 бүртгэл хийж 6 гэрчилгээ олгож ажиллалаа.

Нийгмийн даатгал болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулиудын шинэчилэлтээр 12 дугаар сард 686 хүнд зөвлөгөө өгч, нийгмийн даатгалд болон эрүүл мэндийн даатгалд малчид, ХХЭ, ажилгүй иргэдийг сайн дурын даатгалд

хамрагдах талаар танилцуулан ажиллаж тараах материал болон гарын авлагыг 256 хүнд тарааж ажилласан. Нийгмийн даатгалын шимтгэлд 5 байгууллага, 29 аж ахуйн нэгжийн 383306.2 мян.төгрөгийн, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 136 хүний 31689.1 мян.төгрөгийн шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 156 хүний 10216.4 мян.төгрөгийн хураамжийг холбогдох дансанд төвлөрүүлж ажилласан.

Сумын онцгой комисс болон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас 1, 2-р багнийн 32 өрхөд хонь, ямаа, 45 өрхөд хөнгөлөлттэй нүүрс, 1 удлаагийн маск 123 өрхөд 1230 ширхэг, 12 өрхөд 50.000 төгрөгийн хүнсний тусламж, 6 иргэнд сүү аарц, 1 иргэнд 2 кг чацаргана, 1800.000 төгрөгийг хувааж сумын Онцгой комисс, ЭМТ, Цагдаагийн хэсэг болон олон хүүхэдтэй, АБТДО-той ахмад настантай өрхүүдэд хандивлалаа.

Онцгой комисст иргэдээс үхэр 2, хонь 9, ямаа 4, сүү 53 л, аарц 31 л, 4 шуудай хүнсний ногоо, 5300 ширхэг амны хаалт, 1 тэвш түлээний мод, 200.000 төгрөгийн хүнс, чацаргана 10 кг, гар ариутгагч 15 л хандивласан.

Сумын ерөнхий боловсролын сургууль сайн үйлсийн аянг 12-р ангийн эцэг эх, асран хамгаалагчдын дунд зарлан, 21 өрх айлын 36 сурагчид хүнс, ахуйн хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/335, сумын Засаг даргын А/247 тоот захирамжийн дагуу 2020 оны жилийн эцсийн мал тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллогыг сумын хэмжээнд зохион байгууллаа.

2020 оны улаанбуудайн урамшуулалд 14 аж ахуйн нэгжийн хамруулахаар бэлтгэл ажил хангагдаад байна.

- Орон нутгийн хөгжлийн сангийн 98.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын Соёлын төвийн их засварыг ажлыг хийж гүйцэтгэлээ.

- Төв замын тэмдэг тэмдэглэгээ, зам засварын ажлыг 20.0 сая төгрөгөөр хийж, ажлын гүйцэтгэл 50 хувьтай явагдаж байна.

- Даагат 1-р багийн Бумбат тохойн айл өрхүүдийг эрчим хүчинд холбох шугам, сүлжээний ажлыг 20.0 сая төгрөгөөр “Хөтөл цэнэг” ХХК, тус багийн гудамж талбайн гэрэлтүүлэгийн ажлыг 20.0 сая төгрөгөөр “Амар констракшн” ХХК тус тус 100 хувь гүйцэтгэлээ.

- Цагаан идээ боловсруулах цехийн тоног төхөөрөмж худалдан авах ажлыг 15.0 сая төгрөгөөр “Базаар саплай” ХХК 100 хувь гүйцэтгэн хүлээлгэж өгсөн боловч цехийг бүрэн ашиглалтад оруулахын тулд 2021 оны төсөвт гүнийн худаг гаргах зардлыг тусгуулж ажиллалаа.

Сумын хэмжээнд 426 өрхөд 2570 м3 мод буюу шинэс 1016 м3, хус 376 м3, улиас 837 м3, нарс 92 м3, хэрэглээ 225 м3 олгож, 3558.030 төгрөгийн нөөцийн төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэн ажиллалаа.

Хүдэр сүм:

Сумын хэмжээнд “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 86.5 хувьтай, сумын Засаг даргын хөтөлбөрийн биелэлт 83.3 хувьтай байна. Эдгээр хөтөлбөрүүдийг жил бүрийн ажлын төлөвлөгөөнд тусган сумын нийт албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ажлын тодорхой чиглэл өгч, биелэлтэд хяналт тавин ажиллалаа.

Сумын Засаг даргын Тамгын газар ажлаа жил, улирлаар төлөвлөн биелэлтийг тухай бүр тооцон ажилласан ба үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 79 хувьтай байна.

Засаг даргын Тамгын газрын авлигын эсрэг үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг шинээр боловсруулан мөрдөж ажилласнаар төрийн албан хаагчид иргэдэд төрийн үйлчилгээг чирэгдэл, хүнд сурталгүй шуурхай хүргэх, байгууллагын ажил үйлчилгээ, мэдээллийн ил тод байдлыг хангах журмыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Тайлангийн хугацаанд сумын Засаг даргын зөвлөлийн хурлыг 2 удаа, Тамгын газрын албан хаагчдын хурал зөвлөгөөнийг 3 удаа зохион байгуулж, төлөвлөсөн шийдвэрийн биелэлт болон бусад цаг үеийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, жилийн эцсийн ажлаа дүгнэлээ.

Сумын байгаль орчны алба, Эрэн хайх аврах салбарын албан хаагчидтай хамтран Хүдэр сумын Нүхэн гарц пост сумаас гарах орох хөдөлгөөнийг хааж, шаардлагатай зайлшгүй шалтгаанаар гарах, орох тээврийн хэрэгсэлд хяналт тавин ажиллаж байна.

Энэ хугацаанд постоор :

1. Ар гэргийн гачигдалаар 34 машин 126 иргэн
2. Хүнс татах 32 машин 55 иргэн
3. Эрүүл мэндийн шалтгаан 23 машин 73 иргэн
4. Албан ажлаар 3 машин 12 иргэн нийт 92 машин 266 иргэн нэвтрэх зөвшөөрлийн бичгээр хөдөлгөөн үйлдсэн байна. Шаамар сум, Дулаанхаан тосгоноос түлээний модонд явж байгаа тээврийн хэрэгсэлийг эрхийн бичгийг үндэслэн нэвтрүүлэн ажилласан.

Аймгийн Онцгой комиссын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тус суманд самар түүхээр ирсэн нийт 121 тээврийн хэрэгслээр 691 иргэнийг журмын дагуу зохих халдвар хамгааллыг дэглэмийг мөрдөн ариутгал хийж, эрүүл мэндийн асуумж хуудсыг бөглүүлэн гарах хөдөлгөөнийг зохион байгуулж, 817 иргэн орон нутагтаа буцсан.

Сумын Засаг даргын А/125 тоот захирамжийн дагуу сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 13 хүнсний дэлгүүрийн цагийн хуваарь, архи, согтууруулах ундаа худалдан борлуулахгүй байх тал дээр хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Улаанбаатар хотын “Хот тохижилт”-ын анчидтай хамтран золбин нохой устгах ажлыг зохион байгуулж 55 нохой устган устгалын цэгт хүргэж халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа. COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэх ажлыг нийт 112 цэгт 30 удаагийн давтамжтай 42400 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа.

2020 оны намрын ургац хураалтын ажилд нийт 8 аж ахуй нэгж 52 ногоочин 12 механикжуулагч 80 түр ажилчин ажиллаж, улаанбуудай 6250 га-аас 6250 тн, арвай 180 га-аас 134 тн, овьёос 200 га-аас 349 тн, тэжээлийн ургамал 117га-аас 125 тн, рапс 470 га-аас 45 тн, төмс 72га-аас 620 тн , хүнсний ногоо 46 га-аас 421 тн хураан авлаа.

Сум хөгжүүлэх сангийн зээлийг 2010 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс одоог хүртэл 188.800.000 төгрөгийн зээлийг олгож, хүү 8132.940 төгрөг, алданги

525.000 мян.төгрөг байна. 2020 онд төлсөн алданги 45.000 мян.төгрөг, зээлийн нийт үлдэгдэл 154.463.340 төгрөг байна.

2020 онд бизнесийн зориулалтаар 7 байршлын 3200 га-д 20000 тн хадлан, малчин, мал бүхий иргэд 5500 тн хадлан, сумын нөөцөд 20 тн хадлан бэлтгээд байна.

“Малчны оргил” хоршооны төлөөлөгчөөр дамжуулан “Дарханы нэхий” үйлдвэрт 34 малчин өрхийн хонины нэхий 81, үхрийн арьс 222 нийт 303 арьс тушаан, урамшуулалд хамруулан 100 хувь олгож, ямааны ноолуурын урамшуулал олгох 9823 ямааны 58.938.000 мян.төгрөгийг малчин, мал бүхий иргэдийн дансанд шилжүүлж ажиллалаа.

Тайлант сард Аймгийн Засаг даргын 2020 оны А/355, сумын Засаг даргын 2020 оны 139 тоот захирамжаар мал тэжээвэр амьтад, хашаа худгийн ээлжит тооллогын ажлыг зохион байгуулж 16 чиглэлд 48 албан хаагч явж мал тооллогын ажил дуусаж нэгтгэлийн ажил хийгдэж байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 147 тоот тогтоолоор сумын 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлагдсан. Төлөвлөгөөнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 2 байршилд 30 иргэнд 7.5 га газрыг өмчлүүлэхээр тусгагдсанаас тайлант онд газар өмчлүүлэх ажлын хүрээнд жилийн эцсийн байдлаар сумын Засаг даргын 2020 оны А/37, А/89, А/127 тоот захирамжаар нийт 5.21 га газрыг 18 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлсэн. 2003-2020 хооронд сумын хэмжээнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нийт 1559 иргэн газар өмчилж, сумын хүн амын 58.9 хувь нь газраа өмчилсэн байна.

Сумын Засаг даргын 2020 оны А/96 тоот захирамжаар бизнесийн зориулалтаар 19 аж ахуйн нэгж, 68 иргэнд 3200 га байгалийн хадланг гэрээгээр ашиглуулах ажлыг зохион байгуулсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 152, 165 тоот тогтоолоор 25 аж ахуй нэгж, 6 нөхөрлөлд хэрэглээний мод 15.510 м3, түлээний мод 13.435 м3 хувиарлаж, сумын Засаг даргын “Ойгоос мод бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд хэрэглээний мод 10.075 м3 буюу 64.9 хувь, түлээний мод 4946 м3 буюу 36.8 хувьтай бэлтгээд байна.

2020 онд ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуй нэгж, байгууллагын өөрийн хөрөнгөөр нийт 252 га талбайд ойжуулалт хийхээс 269 га талбайд хийж гүйцэтгэсэн байна. Мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ 886 олгож 18.984 м3 мод гадагш тээвэрлэгдсэн байна.

Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Дошинт”, “Нүхэн” гүүрний хяналтын цэгт үзлэг шалтгалтыг хийхэд “Ойн тухай хууль” зөрчсөн иргэн, аж ахуй нэгжийн нөхөн төлбөр 10042.0 мян.төгрөг, зохих зөвшөөрөлгүй эзэн холбогдогч нь тодорхойгүй бэлтгэгдсэн 90 м3 нарсан гуалинг сумын Засаг даргын 2018 оны А/47 тоот захирамжийн дагуу дуудлага худалдаа зохион байгуулж 11000.0 мян.төгрөгийг тус тус орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллалаа.

“Дархан Төмөрлөгийн Үйлдвэр” ХК-ий 2020 оны УАТ тусгагдсаны дагуу “Цагаан зүрийн гол” гэх газар 15 га талбайд дүйцүүлэн нөхөн сэргээлт хийж аймгийн БОАЖГ, сумын комисс хүлээн авч ажилласан.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны А/98 тоот тогтоолын дагуу ойн дагалт баялаг ашиглах, хамгаалах эрхтэй мэргэжлийн 26 аж ахуй нэгж гэрээ байгуулснаас 17 аж ахуй нэгж 775 тн самар бэлтгэж, 11 аж ахуй нэгж 350 тн самар гадагш тээвэрлэсэн байна. Нийт 139 иргэн ахуйн зориулалтаар 3475 кг хуш модны самар түүж бэлтгэсэн байна.

Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд “Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх төлөвлөгөөний дагуу Тарвагатай 1-р багт байрлах хогийн цэгийн ойр орчмын хог болон үртэс хаях цэгт зам гарган овоолго үүсгэн цэвэрлэх ажлыг “Дархан төмөрлөг” ХК болон мод бэлтгэлийн 25 аж ахуй нэгжтэй хамтран 15 га талбайн хогийг цэвэрлэсэн.

Цагааннуур сум:

Аймгийн Засаг даргын А/335 дугаар захирамжаар 2020 оны Мал, тэжээвэр амьтдын улсын тооллогыг зохион байгуулж сумын нэгдсэн дүнгээр нийт 181652 толгой мал тоолууллаа.

Сумын Шуурхай штабт ЗДТГ-ын албан хаагчид 24 цагийн ээлжээр ажиллан, цаг үеийн мэдээллийг иргэдэд хүргэн, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

12 дугаар сарын 02-25-ны өдрийг хүртэл нийт 348 иргэн ирж, 266 өрхийн 683 иргэн тусгаарлагдсан байна. Өдөр бүрийн эргүүл жижүүрийг томилон хувиарлаж, тусгаарлагдсан иргэдийн хөл хорионы дэглэмд хяналт тавих, хүнсний дэлгүүрүүдийн ариутгал халдваргүйтгэл болон үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын А/360 захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Цагдаагийн газартай 3 хоног хамтран ажиллаж, уг ажлын хүрээнд захирамжийн хавсралтад зааснаас бусад хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахгүй байх, архи согтууруулах ундаа худалдан борлуулах үйлдлийг таслан зогсоох талаар сумын хэсгийн төлөөлөгч нартай хамтран ажиллалаа.

Иргэний бүртгэлийн чиглэлээр: Төрсний бүртгэл 5, гэрлэсний бүртгэл 2, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 21, иргэний үнэмлэх дахин авах бүртгэл 1, иргэний үнэмлэх олголтын бүртгэл 10, лавлагаа олголт 24, иргэний үнэмлэх дахин авах бүртгэл 1 лавлагааг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас олгон ажиллаж байна.

Нийгмийн даатгалын чиглэлээр: Тэтгэврийн даатгалын сангаас 450 өндөр настанд 166.453.8 мян.төгрөг, 46 тэжээгчээ алдсан иргэнд 15.050.0 мян.төгрөг, 223 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 74 218.2 мян.төгрөг, 4 цэргийн өндөр настанд 2508.0 мян.төгрөг, ҮОМШӨ даатгалын сангаас 4 иргэнд 1417.6 мян.төгрөг,

Тэтгэмжийн даатгалын сангаас: Хөдөлмөрийн чадвараа түр алдсан 13 иргэнд 3.5369.5 мян.төг, амаржсан 1 эхэд 1.488.4 мян.төгрөг,

Ажилгүйдлийн даатгалын сангаас: 4 даатгуулагч 2.026.9 мян.төгрөгийг тус тус олгоод байна.

Халамжийн сангаас нийт 1444 иргэний 714752.0 мян.төгрөг олгоод байна.

Бүх нийтийн бэлэн байдал зарласантай холбогдуулан, эцэг эх, асран хамгаалагч нар нь харъяалалын бус орон нутагт хөл хорионд орсон, гэртээ асран хамгаалагчгүй үлдсэн хүүхдүүдийн бүртгэлийг гарган, сургуулийн нийгмийн ажилтан, сумын Онцгой комисс, шуурхай штабын эргүүл жижүүртэй хамтран, хараа хяналт тавин ажиллаж, хөл хорионы улмаас хүнсний дутагдалд орж

болохуйц иргэдийн судалгааг гарган, АБТДО-той иргэд, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настан, зорилтот өрх, гэр бүлийг дэмжих хөтөлбөрийн нийт 122 өрхөд хүнсний болон өргөн хэрэглээний бараа материал, 113 өрхөд 558 шуудай нүүрс, 18 өрхөд модны дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллалаа.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн 2 кейс дээр ажиллан, судалж байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар сумын 2021 оны төсвийг хэлэлцэн баталсан. Төсөвт байгууллагуудын 2020 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор ашиглалтын хугацаа дуусч, цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй, стандартын шаардлага хангахгүй болсон 125 төрлийн 9058440 төгрөгийн хөрөнгийг сумын Засаг даргад танилцуулан сумын ИТХ-аар хэлэлцүүлэн актлуулсан.

Сумын татварын орлого 151447.7 мян.төгрөгийн төлөвлөгөөтэйгээс 198573.3 мян.төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 131.1 хувийн биелэлттэй, орон нутагт аймгаас ирэх санхүүгийн дэмжлэг 883422.1 мян.төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирэхээс 728123.5 мян.төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирсэн. Орон нутгийн байгууллагуудын санхүүжилт олгогдсон байна.

ОНХС-ийн санхүүжилт 157284.6 мян.төгрөгийн санхүүжилт ирж 149185.2 мян.төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн Засаг даргын А/309 захирамжийн дагуу “Өвлийн идэш-2020” арга хэмжээний хүрээнд Сүхбаатар сумын 11 иргэнд өвлийн идэш 2.6 тн мах хүргэх ажлыг зохион байгуулсан.

Сумын хэмжээнд 15902 тн өвс, 2206 тн таримал тэжээл, 2.9 тн гар тэжээл, 271.5 тн хужир, 6.5 тн хүнсний ногооны хаягдал, 301.9 тн үр тарианы хаягдал, 2605 тн сүрэл, 269.4 тн аргал, 545.3 тн хөрзөн, 3016.5 тн түлшний мод, 6 тн самар бэлтгээд байна.

Аж ахуйн нэгж байгууллага иргэдээс 2021 онд 17333 га тариалах талбайн хэмжээ, үрийн нөөцийг урьдчилсан байдлаар гаргууллаа.

Сэлэнгэ бүсийн Сум дундын ойн анги, байгаль хамгаалагч нар “Цагааннуур баялаг ирээдүй” нөхөрлөлийн талбай тусгаарлалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Мод бэлтгэлийн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх зорилгоор 12 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн “Ламхай овоо”, “Их Хүнгэ”, “Бага Хүнгэ” чиглэлд хөдөлгөөнт эргүүлийг томилон ажиллуулж, мод бэлтгэх эрхийн бичиггүй тээвэрлэгдэн орж ирсэн модыг хураан авч, зөрчлийг арилган ажиллаж байна.

Шаамар сум:

Монгол Улсын Шадар сайдын 146 тушаалаар “Зорчигч тээврийн үйлчилгээг зохион байгуулах түр журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллалаа.

12 дугаар сарын байдлаар сумын Засаг даргын А захирамж 14 , Б захирамж 5, сумын Засаг даргын Тамгын даргын А тушаал 1, Б тушаал 4, сумын Засаг дарга, Тамгын газрын даргаас явсан бичиг 47, аймгийн Засаг даргын Тамгын газраас 27 бичиг ирснээс хариутай 13 бичигт хяналт тавьж хариуг хүргүүлэн ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын 178 тогтоол, Сэлэнгэ аймгийн Засаг даргын А/306, А/310, А/311, А/324, А/332 захирамж, Сэлэнгэ аймгийн Онцгой комиссын 05 тоот тогтоолын дагуу зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын болон зарим төрлийн үйл ажиллагааг түр зогсоож цагийн хязгаарлалт тогтоож, бүх нийтийн бэлэн байдлын горимыг хэрэгжүүлж захирамжаар гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдалд

шилжүүлсэнтэй холбогдуулан 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр 06:00 цаг хүртэл хугацаагаар сунгаж нэмэлт өөрчлөлт оруулсны дагуу тусгаарлах байр, өдөр бүр сумын хэмжээнд эргүүл хяналтыг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр, шуурхай штабыг 24 цагаар, Шаамар 6, 34-р точикуудад цагдаагийн постыг тус тус ажиллуулж байна.

Аймгийн Засаг даргын А/340 дүгээр захирамжаар “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай” Сүхбаатар, Алтанбулаг сумаас бусад суманд хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааг хэвийн явуулж байна.

Аймгийн Засаг даргын А/335 дугаар захирамжаар Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн ээлжит тооллого зохион байгуулж Дэлгэрхаан 1-р баг 207 өрх, Охиндий 2-р баг 154 өрх, Дулаанхаан 3-р багийн 223 өрх нийт 584 өрхийн шивэлтийн ажлыг хийж аймгийн Статистикийн хэлтсээс гаргасан хуваарийн дагуу цахимаар шалгуулан хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.

Нас барсны гэрчилгээ авах хүсэлт гаргасан 5 иргэн, төрсний гэрчилгээ 1, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд шинээр 1 иргэнд, 25 ба 45 насны иргэн үнэмлэх солиулах 1 иргэн, шилжин ирэх хүсэлт гаргасан 2 иргэний бүртгэлийг хийж, оршин суугаа хаягийн лавлагааг 1 иргэнд, гэрлэлтийн лавлагаа 1 иргэнд, төрсний лавлагааг 1 иргэнд, гэрлэлт бүртгэлгүй лавлагаа 1 иргэнд нийт 4 лавлагааг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас олгон ажиллалаа.

Нийгмийн даатгалын сангаар 23 ажил олгогч, сайн дурын даатгалд 1 иргэнийг хамруулж нийт 49667.57 сая төгрөг төвлөрүүлж ажиллахаас 12 сард 73912.50 сая төгрөг төвлөрсөн байна. Тэтгэврийн даатгалын сангаас 349 өндөр настанд иргэнд 132906503 сая төгрөг, 94 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 30137562 сая төгрөг, 26 тэжээгчээ алдсан иргэнд 8500000 мян.төгрөг, цэргийн 5 өндөр настанд 3277589 төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний амаржсаны 1 иргэнд 12636700 төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 1 иргэнд 416024 мян.төгрөг, жирэмсний амаржсаны 2 иргэний 3676440 мян.төгрөгийг тус тус олгоод байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах 22 өргөдөл хүлээн авч холбогдох баримт бичгийг бүрдүүлэн шаардлагатай материалуудыг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж дээд шатны байгууллагад уламжлан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид байнгын асаргаа 9 хүн, цалинтай ээж 3 хүн, жирэмсэн эх 1 хүн, ахмадын амралт, сувилал 3 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт 1 хүн, шинэ төрсөн хүүхдийн мөнгөнд 1 хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийн сунгалт 4 хүн, хүнс авдаг 12 өрхийн 89 гишүүнд 12 дугаар сарын хүнсний тэтгэмж болох 1.600.000 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллага болох "Бүтээл сан" ХХК-ий "Шонхлой" хүнсний дэлгүүртэй хамтран олгож олгосон тайланг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажиллалаа.

Газар хүссэн нийт 36 өргөдөл хүлээж авснаас, газар эзэмших эрх шилжүүлэх 2, газар эзэмших эрхийн гэрчилгээ шинэчлүүлэх 4, Хамтран өмчлөгч салгуулах 5 иргэний хамтран өмчлөгчийг салгах хүсэлтээ ирүүлсэн 4 иргэний өргөдөл хүсэлтийг шийдвэрлэсэн. Мөн ААН байгууллагад 512 нэгж талбарын газрын төлбөрийн нэхэмжлэлийг үүсгэсэн байна. Түлээ нүүрсний татан авалтыг

аймгийн Онцгой комиссоос гаргасан шийдвэрийн дагуу 12 дугаар сарын 01-06-ны хооронд нийт 45 өрх 225 м3 түлшний мод татан авсан байна.

УИХ-ын гишүүн Д.Өнөрболорын тусламжаар тосгоны нийт 120 өрхөд 24 тн нүүрсийг хуваарилан өгч ажиллалаа. Тосгоны төв халаалтын уурын зуух нийт 70 тн буюу 20 хоногийн нөөцтэй байна.

ХЯНАСАН:
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Ц.РЭГЗЭДМАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
МЭРГЭЖИЛТЭН Д.АЛТАНТУЯА